



Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлж, иргэдийг экологийн цэвэр эрүүл хүнсээр хангана.

**Зорилт 1.2.** Газар тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэт шинэ техник технологийг нэвтрүүлж, усалгаатай талбайг нэмэгдүүлэн, эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулах замаар тогтвортой ажлын байр бий болгоно.

Хүрэх үр дүн: Аж ахуйн нэгж, иргэдийн эзэмшилд байгаа эргэлтийн талбайг 100 хувь ашиглаж, нэгжийн ургацын хэмжээг нэмэгдүүлэн, дотоодын хэрэгцээг гурил, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамлаар 100 хувь, жимс жимсгэнээр 10 хувь хангана.

**1.2.1.** Усалгаатай тариалан эрхлэх талбайн судалгааг шинэчлэн гаргаж, услалтын системийн ашиглалтыг сайжруулж томоохон голын сав нутгаар усалгаатай тариалан эрхлэхэд дэмжлэг үзүүлэх **/2013-2016/**

*Усалгаатай тариалан эрхэлж болох 7.1 мянган га талбайг нарийвчлан судалж услалтын систем шинээр барьж болох талбайг шинэчлэн гаргахаар ҮХААЯ-наас манай аймагт 2013 онд хийхээр төлөвлөсөн боловч уг ажил хийгдээгүй 2014 онд хийхээр хойшилсон.*

*Сэлэнгэ Хутаг-Өндөр, Тэшиг, Орхон голын дагуу байрлалтай талбайд аж ахуйн нэгж иргэд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон услалтын систем бүхий 2500 га талбай эзэмшиж 2000 га-д тариалалт хийж, 500 га-д урини боловсруулалт хийсэн байна.*

**/Тухайн жил 70 хувь/  
/Өссөн дүнгээр 17,5 хувь/**

**1.2.2.** Газар тариалангийн техникийн дундын парк байгуулах ажлыг өрнүүлж, тариалан эрхлэгчдийн технологит ажлыг бүрэн гүйцэтгэх нөхцлийг хангах **/2013-2016/**

*Хутаг-Өндөр, Сэлэнгэ сумдын Техник дундын парк ажиллаж 120 иргэн, 11 аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлж нийт 320 га талбайд тариалалт хийлээ. Ингэснээр өмнөх оноос 15 хувиар өслөө.*

*Бага оврын тариалангийн техник тоног төхөөрөмжийн дундын парк 6 суманд ажиллаж хаврын тариалалтыг хугацаанд нь хийж дуусгалаа.*

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**1.2.3.** Чацаргана хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, суулгац үйлдвэрлэх замаар тариалалтыг жил бүр 20-оос доошгүй га-аар нэмэгдүүлэх **/2013-2016/**

*Чацаргана хөтөлбөрийн хүрээнд 42750 ш суулгацыг 40 га талбайд шинээр тариалж, нийт жимс жимсгэний талбайн хэмжээ 360 га-д хүрэв.*

*Суулгац үйлдвэрлэх жимс жимсгэний аж ахуй байгуулах 5.0 га-ийн төслийн тендерт Баяннуур, Гурванбулаг, Булган сумын 5 иргэн 1 аж ахуйн нэгжийн төсөл шалгарч тус бүр 5.0 сая төгрөгийн санхүүжилт авлаа. Чацаргана тариалалт тайлант онд 45 га-аар нэмэгдлээ.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**1.2.4.** Өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжиж бага болон дунд оврын техникийн дундын парк байгуулан, хүнсний ногооны тариалалт, арчилгаа, хураалтын ажлыг механикжуулах замаар нэгжийн ургацыг нэмэгдүүлэх **/2013-2016/**

Өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжиж бага оврын техник, хүлэмжээр хангах ажлыг зохион байгуулж, ҮХААЯ-ны хөнгөлөлттэй бага оврын трактор 98-ыг авч хаврын тариалалт, ургац хураалтанд ашиглалаа. Үүний үр дүнд өрхийн тариалангийн хэмжээ хүнсний ногоо 343 га-д хүрч 4.2 мянган тн ургац хураан авч, нэгжийн ургацын хэмжээ 121 цн хүрэв.

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**1.2.5.** Булган, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгонд өвөл зуны хүлэмжийн аж ахуй байгуулж, хамгаалагдсан хөрсний тариалалтыг нэмэгдүүлэх **/2013-2016/**

Хялганат тосгонд “Шим мандал” ногоочдын бүлэг 120 м/кв талбай бүхий 2 хүлэмж, 2 иргэнд 120 м/кв талбай бүхий хүлэмж, нийт 240 м/кв, Хутаг-Өндөр суманд 4 иргэн 170 м/кв талбайд, Булган суманд 1 иргэн 3 сая төгрөгийн дэмжлэг авч 85 м/кв талбай бүхий 2 хүлэмж шинээр ашиглалтанд оруулаа. Бусад сумдад 18 хүлэмж шинээр ашиглалтанд орж тариалалт хийгдэв.

Өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулахаар тус сумдын ард иргэдээс захиалга авах ажлыг зохион байгууллаа.

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**1.2.6.** Эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран үрийн аж ахуй байгуулж, ганд тэсвэртэй, сайн чанарын нутагшсан үрээр дотоодын хэрэгцээг хангах, үр үржүүлэг, судалгаа шинжилгээний туршилтын талбай бий болгох **/2013-2014/**

Үрийн аж ахуй байгуулах боломжтой аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах судалгаанд манай аймгийн Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Орхон сумдын 5 аж ахуйн нэгж шалгуур үзүүлэлтийг хангасан тул үр үржүүлэх саналыг ҮХААЯ, УГТСЭШХ-нд хүргүүлэв.

Ургамал газар тариалан сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэнГТЭСЭШХ-тэй хамтран үрийн аж ахуй байгуулах төсөлд санал өгөх хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Энэ жил нийт 410 тн үрийг ТЭДС-аас хөнгөлөлттэй нөхцлөөр, 25 тн Дархан 34 сортын үрийг УГТСЭШХ-ээс худалдан авч, үр шинэчлэхээр тариалалт хийгдэж ирэх жилд тариалах 100 тн үрийн нөөц бүрдүүлээд байна.

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 30 хувь /**

**1.2.7.** Хутаг-Өндөр суманд 15 мянган тн багтаамжтай үр тариа хадгалах элеватор байгуулах **/2013-2014/**

Хутаг-Өндөр суманд 15 мянган тн-ын элеваторыг 2014 онд улсын төсвийн хөрөнгөөр барихаар шийдвэрлэсэн.

**/Тухайн жил 100 хувь /**

**/Өссөн дүнгээр 70 хувь /**

**1.2.8.** Таримлын сэлгээний тоог нэмэгдүүлж, хөх тариа, шар буурцаг, царгас, эрдэнэ шиш, вандуй зэрэг таримлыг ээлжлэн тариалж, тариалангийн талбайн үржил шимийг хамгаалах **/2013-2016/**

*Үр тарианы 6, тэжээлийн 3 таримал болон тосны 2 төрлийн таримлыг сэлгээнд оруулан тариалж байна. Буудайнаас бусад таримлын эзлэх хувь 4.7 хувийг эзлэж байна. Арвай 282.0 тн, хошуу будаа 1091 тн, хөх тариа 125 тн, бог будаа 23 тн хураан авсан.*

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**1.2.9.** Тэжээлийн ургамлын тариалалтыг жил бүр нэмэгдүүлж, малын тэжээлийн дотоодын хэрэгцээг бүрэн хангах **/2013-2016/**

*Энэ онд нийт 443 талбайд ногоон тэжээл, 814 га-д тэжээлийн овьёос тарьж, 943 тн ногоон тэжээл 1091 тн хошуу будаа хураан авч дотоодын хэрэгцээгээ 100 хувь хангаад байна.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**1.2.10.** Тариаланч, механикжуулагч, мэргэжилтнүүдийг дотоод, гадаадын сургалтанд хамруулж, туршлага судлуулах **/2013-2016/**

*Аймгийн тариаланчдын зөвлөгөөнийг Тэшиг, Хутаг-Өндөр, Хялганат, Бүрээхангай суманд бүсчлэн зохион байгуулж, 250 гаруй механикжуулагчид хамрагдав. Төмс, хүнсний ногооны эрчимжсэн технологи болон жимс жимсгээний сургагч багш бэлтгэх сургалтанд 6 хүн хамрагдан сертификат авав. Тариаланчдын холбоо, “Вагнер Ази” ХХК-н Дархан-Уул аймаг дахь ХАА-н салбартай хамтран тариаланчдын Фарм-шоу зохион байгуулж 40 гаруй тариаланч оролцов. Уг арга хэмжээний үеэр шинэ техник оруулж ирж байгаа 20 гаруй аж ахуй нэгжийн техник, тоног төхөөрөмж, сэлбээгийн үзэсгэлэн худалдаа, туршилтын талбайд тариагдсан 20 гаруй сортын танилцуулга үзүүлсэн. Мөн БНХАУ-ын Хунян мужид 1, БНСУ-ын газар тариалангийн үйлдвэрлэлийн танилцах аялалд 2 хүн оролцож туршлага судлууллаа.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**Зорилт 1.3.** Мал үржлийн ажил үйлчилгээг сайжруулж, төв суурингийн ойролцоо эрчимжсэн аж ахуйнуудыг байгуулж, эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар малын тоон өсөлтийг тогтворжуулж, салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

*Хүрэх үр дүн: Өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх тоо хэмжээ 15 хувьд хүрч, нэг малаас авах ашиг шимийн үзүүлэлт 10 хувь нэмэгдэнэ.*

**1.3.1.** Хангай үүлдрийн хонины генофондыг хамгаалж, тоо толгойг 2 дахин нэмэгдүүлэх **/2013-2016/**

*Хангай үүлдрийн хонины тоо толгой цөөрч, үндсэн үүлдэр чанар алдагдаж байгааг үзлэг ангилалт хийж тогтоолоо.*



**/Өссөн дүнгээр 17,5 хувь/**

**1.3.5.** “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлж, сумдын *Ì Ƴ-Ò*-ийг шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаж, мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулан, үүрэг хариуцлагыг сайжруулах **/2013-2016/**

*“Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүллээ. Хөтөлбөрийн хүрээнд мал жинлэх жин /1000, 60 ёа/, *ì àèèì àò ð, èáí ò ì àò ð, àðáí ì àò ð* *сүдүя í èèò 443.7 ñàÿ ò °ãð°áí èé* *¿ðæèèéí ááãàæ* *õýðýáñèèéá* сумдад хуваариллаа.*

*ҮХАА-н сайд, Хөдөлмөрийн сайдын 2013 оны хамтарсан тушаалаар нийт 14125 ширхэг мэргэжлийн малчин үнэмлэх, энгэрийн тэмдэгийг малчдад олголоо.*

*Аймгийн мал аж ахуйн мэргэжилтний зөвлөгөөн зохион байгуулж 170 мэргэжилтэн оролцлоо. ҮХААЯ-аан *сi õèí í áàéãóóèæ áóé áí ä ì àèÿí* *¿ðæ¿èãèéí* техникч бэлтгэх сургалтанд мэргэжилтэн сургалаа. Мянганы сорилтын сангийн Хот орчим бэлчээрийн төслийн сургалтанд ХХААЖДҮГ, ГХБХБГ, Бугат, Бүрэгхангай, Орхон, Сэлэнгэ, Хангал сумдын удирдах ажилтан мэргэжилтэн, малчдын бүлгийн гишүүд 90 гаруй хүн хамрагдав.*

*Ì Ƴ-Ò-ийн мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулж, ажлын байрны тодорхойлолтыг нь танилцуулж, гүйцэтгэх ажлын талаар үүрэг чиглэл өгөв.*

**/Тухайн жил 70 хувь/**

**/Өссөн дүнгээр 17,5 хувь/**

**1.3.6.** Аймаг, сумын түвшинд цаг хүндэрсэн үед ашиглах өвс тэжээлийн нөөц бүрдүүлж, агуулахтай болгох **/2013-2016/**

*Цаг хүндэрсэн үед ашиглах нөөцийн өвс бэлдэх зорилгоор аймгийн Засаг даргын нөөцөөс 210.0 сая төгрөгний хөрөнгийг төлөвлөж хаман боогч 1, хадуур 1, нөөцийн хашаа 100х300 м барьж, аймгийн нөөцөд 981 тн /хонины толгойд шилжүүлсэн малын 30 хувийг 70 хувийн тэжээлээр/ өвс бэлтгэхээс 1018 тн бэлтгэж, 108 хувиар хангасан. Мөн сумдын нөөцөд 981 тн бэлтгэхээс 1250 тн-ийг 124 хувиар хангалаа. Аймгийн мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтийн 2013-2014 оны бэлтгэлийг 88.8 хувиар хангав.*

**/Тухайн жил 100 хувь/**

**/Өссөн дүнгээр 50 хувь/**

**1.3.7.** Тохиромжтой бүс нутагт малын тэжээл үйлдвэрлэх цех байгуулах **/2013-2016/**

*Аймгийн төвд Нөөцийн газарт малын тэжээлийн цех байгуулахаар бэлтгэж ажил хийгдэж байна. Мөн бүх төрлийн тэжээвэр амьтадын тэжээл үйлдвэрлэх үйлдвэр байгуулах судалгаа хийж байна.*

**/Тухайн жил 30 хувь/**

**/Өссөн дүнгээр 10 хувь/**

**1.3.8.** Хадлангийн талбайг эзэмшүүлэх, бэлчээрийг хашиж, хамгаалах ажлыг өрнүүлэх **/2013-2016/**

Аймгийн хэмжээнд нийт 111940.1га хадлангийн талбай байдаг Үүнээс 2013 онд 20058.5 эзэмшүүлэх ажил хийгдсэн. Бэлчээр хашиж хамгаалах ажлыг орон нутгийн хөрөнгөөр Дашинчилэн, Рашаант, Гурванбулаг сумдад 300 га талбай хашиж хамгаалах ажил хийгдлээ..

Бэлчээрийг малын хөлөөс хамгаалах сэлгэж өнжөөх арга хэмжээг 127 мянган га талбайд хийж тодорхой хугацаагаар чөлөөлөх ажил хийгдэв.

Орчны сангийн /GEF/-ын санхүүжилтээр хэрэгжиж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийг Дашинчилэн, Рашаант, Гурванбулаг сумдад хэрэгжүүлэхээр болов.

Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлын хүрээнд Гурванбулаг, Рашаант сумдад микробиологийн аргаар 60.0 мян га талбайд, Баяннуур, Дашинчилэн, Могод сумдад энгийн механик аргаар 20.0 мян га, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд 11 мянган га талбайд зохион байгууллаа.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**1.3.9.** Малын эрсдлийн даатгалд нийт малчин өрхийн 10-аас доошгүй хувийг хамруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ **/2013-2014/**

Малын эрсдлийн даатгалыг 4 дүгээр сарын 1-үүн 6 аймгийн 30-ийг тус тусад нь зохион байгуулж, даатгалын 4 компанийн 36 өрхөөс 7173 малчин өрхөөс 469 малчин өрх буюу 6.5 хувь хамрагдаж. 67.7 мян мал буюу нийт малын 2.6 хувь хамрагдсан байна. Даатгалд Баян-Агт /79 малчин/, Хангал /52/, Булган /47/ сумд сайн оролцсон. Даатгалын хураамжинд 47.7 сая төгрөг төвлөрүүлэв.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**Зорилт 1.4.** Мал эмнэлгийн үйл ажиллагааг технологит хугацаанд нь чанартай хийж, халдварт өвчнийг тандан, шуурхай оношилж, паразиттах өвчнийг бууруулах, урьдчилан сэргийлэх, лабораторийн шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, малыг эрүүлжүүлнэ.

Хүрэх үр дүн: Малын халдварт өвчний гаралтыг 5 хувь, паразиттах өвчний гаралтыг 3 хувь бууруулна.

**1.4.1.** Орчны сангийн төлөвлөгөөний үндэслэлээр хэрэгжиж буй арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай гүйцэтгэх**/2013-2016/**

Мал амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1095.54 мянган толгой мал хамрагдахаас 1065.1 мянган толгой мал хамрагдаж төлөвлөгөөний биелэлт 97.2 %-тай байна. Биокминатаас төлөвлөгөөний дагуу 14 нэр төрлийн 305.3 сая төгрөгний эм биобэлдмэлийг нийлүүлж мал эмнэлэгийн арга хэмжээг технологит хугацаанд нь хийж гүйцэтгэлээ.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**1.4.2.** Мал, амьтны халдварт, паразиттах, бөөллийн, цусан халдварт, дотрын халдварт хордлого, листериоз, галзуу, шөвөг яр, аденоматоз, хорт салст халуурал, дуут хавдар өвчнүүд, паразиттах өвчний онош тогтоолгох шинжилгээнд 47 дээж ирүүлсэнээс гемонхоз, монезиоз, ценуроз, эхникакоз, хамуу өвчнүүд оношлогдон тэмцэх сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах **/2013-2016/**

*Мал эмнэлэг ариун цэвэрийн лаброторид халдварт өвчний шинжилгээнд 831 дээж ирүүлэн 12 суманд цусан халдварт, дотрын халдварт хордлого, листериоз, галзуу, шөвөг яр, аденоматоз, хорт салст халуурал, дуут хавдар өвчнүүд, паразиттах өвчний онош тогтоолгох шинжилгээнд 47 дээж ирүүлсэнээс гемонхоз, монезиоз, ценуроз, эхникакоз, хамуу өвчнүүд оношлогдон тэмцэх сэргийлэх арга хэмжээг тухай бүр нь авлаа.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**1.4.3.** Мал сүргийг хамуу өвчнөөс эрүүлжүүлж, малаас хүнд халдварладаг өвчний гаралтыг бууруулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх **/2013-2016/**

*2013 онд орон нутгийн төсвөөс 8.5 сая төгрөгөөр 1 тн угаалгын бодис, МЭҮН-үүд, малчид өөрийн хөрөнгөөр креолин 0.9 тн, ивомек 250 литрийг татан авч, 627.0 мянган малыг угаалганд, 250.0 мянган малыг боловсруулалтанд хамруулаад байна.*

*Малаас хүнд халдварладаг сүрьеэ, лейкоз өвчнөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**1.4.4.** Бруцелллез өвчнөөс эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, хүн амыг уг өвчнөөс хамгаалах **/2013-2016/**

*2013 онд бруцелллез өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтын арга хэмжээнд 718.4 мянган төл мал хамруулсан. Мөн 5792 үнээ, 7776 хээлтүүлэгч, 3702 бог малыг бруцелллезын шинжилгээнд хамруулсанаас 121 үнээ эерэг дүн үзүүлсэнийг зааврын дагуу нядлах арга хэмжээ авлаа.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**1.4.5.** Мал эмнэлгийн лабораторийн барилга барих хөрөнгө шийдвэрлэгдээгүй байна. Зураг төсөл боловсруулах лабораторийн барилга барих хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар ҮХААЯ-нд хүсэлт гаргаад байна. Монгол мал хөтөлбөрийн хүрээнд мал эмнэлгийн лабораторийн оношлох чадавхийг сайжруулах зорилгоор Полимеразин гинжин урвалаар оношлох багаж авч, мэргэжилтэнийг сургаж дадлагажууллаа.

**/Тухайн жил 30 хувь/  
/Өссөн дүнгээр 10 хувь/**

**1.4.6.** Тэшиг сумын “Бага илэнхи” хилийн боомтод Мал эмнэлэг ариун цэврийн байнгын ажиллагаатай лаборатори байгуулах **/2013-2016/**

*Тэшиг сумын “Бага-Илэнхэн” хилийн боомтод байрлах Мал эмнэлэг ариун өүэдөөй ёааî ðàò î ðийн барилга байгууламж барих асуудлыг Эдийн засгийн хөгжлийн яамнаас зохион байгуулсан санал асуулгын хүрээнд санал өгч холбогдох газарт уламжлав.*

**/Тухайн жил 30 хувь/  
/Өссөн дүнгээр 10 хувь/**

**Зорилт 1.5.**Хоршоо, нөхөрлөл, малчдын бүлэгт тулгуурлан хөдөө аж ахуйн түүхий эд бэлтгэх, бүтээгдэхүүнд анхан шатны тордолт, ангилалт хийх, борлуулах сүлжээ бүхий Хөдөө аж ахуйн биржийг сумдад бий болгоно.

Хүрэх үр дүн: Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр хангагдана.

**1.5.1.**ХАА-н шинэ техник, технологи, таримал ургамлын шинэ сорт, төрөл зүйл туршин нэвтрүүлэх зорилго бүхий ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний туршилтын төвийг байнгын ажиллагаатай болгох **/2013-2016/**

*Одоогийн материаллаг баазад тулгуурлан шинэ техник, технологи, таримал ургамлын шинэ сорт, төрөл зүйл туршин нэвтрүүлэх үйл ажиллагааг цаашид хэвийн явуулах зорилгоор төсөл боловсруулан аймгийн ХАА-н МСҮТ-тэй хамтран туршилт хийх ажлыг явуулахаар боллоо.*

**/Тухайн жил 50 хувь/  
/Өссөн дүнгээр 12,5 хувь/**

**1.5.2.**Сумдад ХАА-н түүхий эд бэлтгэн нийлүүлэх цэгүүдийг бий болгож, Дашинчилэн, Орхон, Хутаг-Өндөр сумдад загвар хоршоодыг байгуулах **/2013-2016/**

*Бүх сумдад ХАА-н түүхий эд бэлтгэн нийлүүлэх цэгүүдийг бий болгож итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг сонгох, тэдэнд үнэмлэх олгох, сургал хийх зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ. Манай аймаг итгэмжлэгдсэн 8 компанид арьс шир бэлтгэн нийлүүлэхээр тогтолоо.*

*Орхон, Баяннуур, Хангал, Хутаг-Өндөр, Бугат зэрэг 5 сумын 5 хоршоонд ХАА-н түүхий эд бэлтгэн нийлүүлэх үйл ажиллагааг дэмжиж, агуулах барих зориулалтаар тус бүр нь 9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг ҮХААЯ-ы мал хамгаалах сангаас олгосны зэрэгцээ Дашинчилэн, Могод, Орхон, Гурванбулаг, Баян-Агт, Булган, Хутаг-Өндөр зэрэг 7 сумын 4 хоршоо, 3 компанид ноос пресслэгч, цахилгаан жин, таар зэрэг нийт 55 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг олгов.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**1.5.3.**Хөдөөгийн иргэдийн хөдөлмөр, хөрөнгөөрөө хоршин ажиллаж, орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүхий л талаар дэмжих **/2013-2016/**

*Малчдад зориулсан “Хоршооны сургалт”-ыг 20 хоногийн хугацаатай бүх суманд зохион байгуулж, судалгаа, санал асуулга авлаа. Орхон, Булган, Дашинчилэн сумдын малчдын зөвлөлгөөнд оролцож, хоршооны зохион байгуулалтын зарчим, хоршооны хууль, малчдын хоршоо байгуулах хэрэгцээ шаардлага, ач холбогдлын талаар сургалт явуулж, мэдээлэл өглөө.*

*2013 оны байдлаар 110 хоршоод татварын хэлтэст бүртгэлтэй байгаа нь өмнөх онтой харьцуулахад 37.0 хувиар өссөн байна.*

**/Тухайн жил 100 хувь/**

**1.5.4.**Тариаланчид, өрхийн аж ахуй эрхлэгчдэд экологийн цэвэр бүтээгдэхүүн тариалах, үйлдвэрлэх сургалт явуулж бодлогоор дэмжих **/2013-2016/**

*Экологийн цэвэр бүтээгдэхүүн, бренд бүтээгдэхүүний талаар нийт сумдын 800 гаруй иргэдэд сургалт явуулж, сумдын Мал эмнэлэг үржлийн тасагт зөвлөмж, сургалтын материал хүргүүлж, хөдөөгийн иргэдэд мэдээлэл хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.*

*2013 онд хүнсний арвай 201 га, хошуу будаа 827 га, бог будаа 21 га-д тариалж экологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлээ.*

*Энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулах 8 төслийг дэмжиж 264,0 сая төгрөгийн зээл олгосон байна.*

**/Тухайн жил 90 хувь/**

**/Өссөн дүнгээр 22 хувь/**

**Жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарт:**

Орон нутгийн түүхий эд, нөөцөд түшиглэсэн дэвшилтэт технологи бүхий нэмүү өртөг шингээсэн жижиг, дунд үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааны салбарын өсөлтийг дэмжиж, ажлын байрыг бий болгоно.

**Зорилт 1.6.** Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэлтийг хөрөнгө санхүү, зээлийн бодлогоор дэмжинэ.

*Хүрэх үр дүн: Хөнгөлттэй зээлд хамрагдсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тоо өсч, шинээр жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ бий болж, иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ.*

**1.6.1.**”Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан”-д 3 тэрбум төгрөгөөс доошгүй хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх **/2013-2016/**

*2013 онд ЖДҮДС- аас 4.9 тэрбум төгрөгийн дэмжлэг хүссэн 138 төслийг төсөл сонгон шагларуулах дэд комиссоор хэлэлцэж 16 төсөлд 503.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээлээр дэмжлэг үзүүлж 78 байнгын ажлын байр бий боллоо. Энэ оны 11 сарын байдлаар ЖДҮДС-аас нийт 104 бизнес төсөл 1.9 тэрбум төгрөгийн зээлтэй байна. 2009 - 2013 ондуудад ЖДҮД дэд санд 3.1 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрээс 164 төсөлд дэмжлэг үзүүлж 300 гаруй ажлын байр нэмэгдүүлсэн байна.*

**/Тухайн жил 100 хувь/**

**/Өссөн дүнгээр 25 хувь/**

**1.6.2.**“Сумын хөгжлийн сан”-гийн эх үүсвэрийг 150 сая төгрөгөөс доошгүй эх үүсвэртэй болгох **/2013-2016/**

*2012, 2013 ондуудад аймгийн хэмжээнд “Сум хөгжүүлэх сан”-д 2230.0 сая төгрөгийн эх үүсвэр нэмэгдэж нийт 3345.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрээс 1739 ажлын байр бий болгох 721 төсөлд хөнгөлттэй зээлээр дэмжлэг үзүүллээ. Сумдын хүн амын тоо, эдийн засгийн багтаамж, зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлага зэргээс хамаарч сумын “Сум хөгжүүлэх сан”-д жилд 50.0-265.0 сая*

төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдэж Булган сум 795.0 сая бусад сумд хүн амын тооноос хамаарч 150.0-180.0 сая төгрөгийн эх үүсвэртэй боллоо.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**1.6.3.** Боловсруулах болон ноос, ноолуур, арьс шир, мах, сүүний үйлдвэрийг дэмжсэн хөнгөлттэй зээлийг орон нутагтаа чиглүүлж, төр хувийн хэвшлийн оролцоог хангаж, дэмжлэг үзүүлэх **/2013-2016/**

Ааа ёй эеёуи ёои уи "I оёо" ООЁ, "а ддò еé ò ддээ" ООЁ, Орхон сумын Орхон мандал ХХК-ууд "Гурилын үнэ тогтворжуулах" д°ò°ёá° дөөс нийт 422.0 сая төгрөгийн хөнгөлттэй сүүё авч үйлдвэрийн үндсэн түүхий эд улаанбуудай худалдан авч үйл ажиллагаагаа явуулж байна.

Булган суманд "Баяндаш хайрхан" ХХК нь "Сум хөгжүүлэх сан", ЖДҮДС-ын 100.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээлийн дэмжлэгийн үр дүнд "Мал нядалгааны цэг, махны хагас боловсруулсан бүтээгдэхүүний цех, 80 тн-ы багтаамжтай хөргүүртэй агуулах"-ыг барьж ашиглалтад оруулж 6 ажлын байр бий болголоо. "Сум хөгжүүлэх сан"-аас арьс шир боловсруулах 2 төсөлд 6.6 сая төгрөг, эсгий эдлэлийн 4 төсөлд 42.5 сая төгрөг, хөргүүртэй зоорь байгуулах 1 төсөлд 50.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олгож 31 ажлын байр бий болголоо. Аймгийн хэмжээнд 6347 малчин, мал бүхий өрхийн 1,3 сая толгой хонины 1.2 сая тн ноос, 50 толгой тэмээний 250 кг ноосыг үндэсний үйлдвэрт тушааж нийт 2.5 тэрбум төгрөгний урамшуулалд хамрагдахаар холбогдох материалыг ҮХААЯ-д хүргүүлээд байна. Урамшууллын мөнгийг 11 сард багтаан малчин, мал бүхий иргэдийн "Хүний хөгжлийн данс"-д төвлөрүүлэхээр ажиллаж байна.

ҮХААЯ, "Арьс шир бэлтгэн нийлүүлэгчдийн холбоо"-той хамтран "Арьс ширэнд урамшуулал олгох журам", гурвалсан гэрээ байгуулах талаар сургалт зохион байгуулж, 16 сумын итгэтжлэгдсэн төлөөлөгчдийг сонголоо.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**1.6.4.** Жижиг бизнес эрхлэгчдэд хөнгөлттэй үнэтэй түрээсийн ажлын байр бий болгох арга замыг судалж, "Бизнес хөгжлийн төв"-ийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах **/2013-2016/**

Сайхан, Бугат, Гурванбулаг, Дашинчилэн, Бүрэгхангай, Орхон сумд ашиглагдахгүй байгаа төрийн өмчийн байрнуудыг жижиг бизнес, ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэдэд хөнгөлөлттэй үнээр түрээслэж ажлын байр бий болгож Булган сумын 2 цэцэрлэгийг шинэ байранд шилжиж орсоны дараа тус барилгыг Булган сумын жижиг бизнес эрхлэгчдийг дэмжсэн ажлын байр болгон зохион байгуулахаар төлөвлөж байна.

**/Тухайн жил 50 хувь/  
/Өссөн дүнгээр 12.5 хувь/**

**Зорилт 1.7.** Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарыг төрөлжүүлэн хөгжүүлж, худалдаа, нийтийн хоолны газруудын эрүүл ахуйн орчин нөхцлийг сайжруулж, шударга өрсөлдөөнийг бий болгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

Хүрэх үр дүн: Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний газрууд төрөлжин хөгжиж үйлчилгээний орчин нөхцөл сайжирна.

**1.7.1.** Мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг дэмжиж, хувийн хэвшлийн салбарт ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах, шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх **/2013-2016/**

Аймгийн “Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг ЭЗХЯ, ҮХААЯ, ЭЗБӨЧ-ын судалгааны төв, мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгууллаа.

400 гаруй бизнес эрхлэгчдийг хамарсан 14 мэргэжлийн холбоодын салбар хуралдаануудыг зохион байгуулж төр, мэргэжлийн холбоод хамтарч ажиллах чиглэлүүдээ тодорхойлсон. Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”- тэй хамтран сумдын “Сум хөгжүүлэх сан”-аас хөнгөлттэй зээлд хамрагдсан бизнес эрхлэгчдэд “Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх” сургалт, Хөдөлмөрийн хэлтсээс 270 иргэнд 11 мэргэжлийн чиглэлээр мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сургалт зохион байгууллаа. Эрхүү хотод зохион байгуулагдаж буй ОУ-ын Үсчин гоо засалчдын тэтгээнд аймгийн 2 үсчинг оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүллээ. Монголын тогооч нарын холбооны 20 жилийн ойг тохиолдуулан ҮХААЯ, Монголын мастер тогоочдын холбоотой хамтран аймгийн сургууль, цэцэрлэг, хүн эмнэлгийн тогооч нарт “Хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт, удирдлагын тогтолцоо, зохистой дадал нэвтрүүлэх нь” сэдэвт сургалт хийж, Аймгийн 2013 оны аварга тогооч шалгаруулах мэргэжлийн ур чадварын тэмцээнийг зохион байгуулахаар бэлтгэж байна. Төв аймагт зохион байгуулагдсан бүсийн аварга тогооч шалгаруулах тэмцээнд аймгийн 3 төлөөлөл амжилттай оролцож 2 тогооч нь МУ-ын мастер тогооч шалгаруулах улсын уралдаанд оролцох батламж авлаа. Дархан -Уул аймагт зохион байгуулагдсан “Кремт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд технологийн шинэчлэл хийх” сэдэвт сургалтад Арвай, Дэлгэрэх, Гурванхас, Маргад зэрэг гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг хамрууллаа.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**1.7.2.** Бизнесийн жишигт нийцсэн худалдааны төв байгуулах санал санаачлагыг дэмжиж, хүнсний захыг хүнсний хяналтын лаборатори, эрүүл ахуйн шаардлага хангасан нийтийн бие засах газартай болгож, орчин нөхцлийг нь сайжруулах **/2013-2016/**

Мах, сүүний гарал үүсэл, эрүүл ахуй, ариун цэвэрт тавих хяналтыг сайжруулах зорилгоор аймгийн төвийн “Баясуулагч” захын дэргэд “Дотоод хяналт”-ын мал эмнэлгийн лаборатори байгуулж, “Сум хөгжүүлэх сан”-аас 3.5 сая төгрөгийн хөнгөлттэй зээлээр дэмжлэг үзүүлж сүүний уураг, чийг, тослог, махны РН тодорхойлогч багажуудыг шинээр авсанаар хүнсний эрүүл ахуй аюулгүй байдалд хяналт тавих ажиллагааг хялбар түргэн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн. Нийт

59779 кг мах махан бүтээгдэхүүн, 10697 л сүү сүүн бүтээгдэхүүнд шинжилгээ хийж 140 гаруй гарал үүсэл бичиж баталгаажуулсан байна.

Аймгийн төвд шинээр “Бизнесийн жишигт нийцсэн битүү худалдааны төв”-байгуулахаар газрын асуудлыг шийдвэрлэлээ.

**/Тухайн жил 50 хувь/  
/Өссөн дүнгээр 12.5 хувь/**

**1.7.3.** Орчин үеийн шийдэл бүхий стандартын шаардлага хангахуйц үйлчилгээний газар байгуулах хувийн хэвшлийн санал санаачлагыг дэмжих **/2013-2016/**

Булган суманд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар дараах томоохон үйлчилгээний газрууд шинээр байгуулагдлаа.

“Номын титэм” ХХК-нь 120 гаруй сая төгрөгийн хөрөнгөөр стандартын шаардлагад нийцсэн 2 давхар худалдаа үйлчилгээний төв ашиглалтад оруулж 30 гаруй худалдаа эрхлэгчдийг түрээсийн шинэ ажлын байртай болголоо. Мөн аймгийн төвд “Хун тайж” ресторан, “Булган” зочид буудал ашиглалтад орж 10 гаруй ажлын байр шинээр бий болголоо.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**1.7.4.** Сумдад ахуйн үйлчилгээний төв байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлэх **/2013-2016/**

2013-2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжуудыг иргэдээр хэлэлцүүлэн эрэмбэлүүлэхэд аймгийн төвд “Ахуйн үйлчилгээний нэгдсэн төв”- барих ажил 5-д эрэмблэгдэж улын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдлаа. Хөдөлмөрийн яаманд ахуйн үйлчилгээний төв болгон ашиглаж болох барилга обектийн судалгааг гаргаж хүргүүлсэн. Булган сум 6 багийн хөгжлийн төвийн зураг төсөвт ахуйн үйлчилгээний цогц үйлчилгээ үзүүлэх өрөө тасалгаатай байхаар тусгаж, Бүрээхангай сум орон нутгийн хөгжлийн сангаас ахуйн үйлчилгээний халаалтын тогоог 4.8 сая төгрөгийн хөрөнгө гарган шийдвэрлэсэн байна. Сайхан сум хуучин ЗДТГ-ын байрыг ахуйн үйлчилгээний төв болгон зохион байгуулж 10-аад ажлын байр бий болгосон байна.

**/Тухайн жил 70 хувь/  
/Өссөн дүнгээр 17.5 хувь/**

**1.7.5.** Булган сумын төвд 2-оос доошгүй нийтийн боловсон бие засах газар байгуулах **/2013 оноос/**

Булган сумын ЗДТГ-ын Хот тохижуулах ангид нийтийн боловсон нүүдлийн “ОО” 1 ширхэгийг худалдан авч хариуцуулан өглөө.

**/Тухайн жил 70 хувь/  
/Өссөн дүнгээр 17.5 хувь/**

**1.7.6.** Сумдын байгалийн баялгийн нөөцөд нь түшиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх. /Булган, Сайхан, Гурванбулаг, Орхон, Хангал, Бугат суманд



суран эдлэл нь Уламжлалт үйлдвэрлэлийн бүсийн шилдэг бүтээгдэхүүний шагнал хүртсэн байна.

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22.5 хувь /**

**Зорилт 1.8.** Үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн: Үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж нэмэгдэж, хүнсний баталгаат байдал сайжирна.

**1.8.1.** Аймгийн төвд БНХАУ-ын хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр хоногт 80 бод, 800 бог мал нядлах, мах боловсруулах үйлдвэр барих ажлыг эрчимжүүлж, аймгийн дотоод хэрэгцээг хангах, томоохон суурин газар, гадаад зах зээлд нийлүүлэх гарцыг судалж хэрэгжүүлэх **/2013-2016/**

Булган сумын 4 баг Домын дэвсэгт улсын төсвийн 100.0 сая төгрөгний хөрөнгөөр мал нядалгааны цэг, 3 тн-ы багтаамжтай гүн хөлдөлтийн агуулах барих барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна. Мөн тус газарт БНХАУ-ын хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр баригдах мал нядлах, мах боловсруулах үйлдвэрийг барьж байгуулахад 1 га газар эзэмшүүлэхээр сумын Засаг даргын захирамжаар шийдвэрлэж, байршлын кадастерын зураг, барилгажсан талбайн дэвсгэр газрын төлөв байдал, орчны цаг уурын мэдээллийг боловсруулан гаргаж холбогдох яаманд нь хүргүүлсэн боловч стратегийн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрийг БНХАУ-аар бариулах нь үндэсний аюулгүй байдалд эрсдэлтэй гэсэн үндэслэлээр ЗГ-ын тогтоол хүчингүй болж үйлдвэр баригдах боломжгүй болсон. “Баяндаш хайрхан” ХХК - нь “Мал мах бэлтгэлийн нэгдсэн төв” - ийг ашиглалтад орууллаа.

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17.5 хувь /**

**1.8.2.** Аймгийн нөөцийн газрыг түшиглэж 150 тн-ын багтаамжтай махны хөргүүртэй зоорь барьж, хүн амын махны хангамжийг сайжруулах **/2013-2016/**

Энэ онд аймгийн нөөцийн газрыг түшиглэж хөргүүртэй зоорь барих ажил төсөвлөгдөөгүй. 2014 онд хүнсний склад, зоорь барих зураг төслийг хийлгэхээр бэлтгэж байна. Аймгийн нөөцийн газар нь хүн амын махны хангамжийг сайжруулах зорилтын хүрээнд 2014 оны хавар аймгийн төвийн хүн амд нийлүүлэгдэх 20.0 тн нөөцийн махыг бэлтгэж Булган сумын ЗДТГ- т хүлээлгэж өглөө.

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17.5 хувь /**

**1.8.3.** Аймгийн төвд хүнс, гурилан бүтээгдэхүүний томоохон үйлдвэр барьж байгуулах санал, санаачилгыг дэмжиж ажиллах **/2013-2016/**

Булган сум “СХС”- аас “Буман сүхэс” ХХК- ны хиамны цех байгуулах төсөлд 10.0 сая төгрөгний зээлээр дэмжлэг үзүүлсэнээр Хиамны цех байгуулагдаж үйл ажиллагаа нь хэвийн явж байна.

Булган сумын “Арвай” талх, нарийн боовны цехэд “Сум хөгжүүлэх сан”-гаас 20.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээлээр дэмжлэг үзүүлсэнээр зориулалтын үйлдвэрийн байр барьж байгаа боловч газрын маргаанаас шалтгаалж барилга барих ажил





**1.9.2.** Бүс, улс, олон улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй үзэсгэлэн худалдаа, бусад бизнес эрхлэлтийг дэмжсэн арга хэмжээнд хувийн хэвшлийг татан оролцуулах **/2013-2016/**

*Нүүгүй ауй, Ойр өа ной айи аацад о адеаеаи аеаи аа адоаи и уааеаи 3 о ое ое ө ө Аади аи Оёһын “Ногоон өдрүүд” үзэсгэлэн яармагт, Оаи аае, Аоёааи ной ии 2 ои дө ии ии төлөөллийг Соёи аи н Оёһаа зохион байгуулагдсан хидө ии ии үеэ ааеёаааааа аа ө аи өөоаа 10 ои ии аеаи адаа оyi ауй а оролцож туршлага судаллаа.*

МУХАУТ-аас зохион байгуулсан "Со саммит" захирлуудын дээд хэмжээний уулзалтад манай аймгийн 3 бизнес эрхлэгч ХАУТ-ын төлөөллүүд оролцлоо.

Улсын "Намрын ногоон өдрүүд 2013" үзэсгэлэн худалдаанд Сайхан, Могод, Сэлэнгэ 1 аж ахуйн нэгж, 8 иргэн, ХХААЖДҮГ-ын холбогдох мэргэжилтнүүд оролцож 150 кг зөгийн бал, 20 кг тоосормог, 4.8 тн айраг, 30 кг бог будаа худалдан борлуулсан байна.

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**1.9.3.** Зах зээлийн судалгаа хийх, зөвлөмжөөр хангах, зар сурталчилгаа, мэдээллийн хүрээг өргөжүүлэхэд төр, хувийн хэвшлийн оролцоог хангах **/2013-2016/**

Аймгийн “Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”-ий үеэр Эдийн засгийн бодлого өрсөлдөх чадварын судалгааны төвтэй хамтран нийгэм, эдийн засгийн голлох үзүүлэлтүүдээр аймгийнхаа өрсөлдөх чадварын боломж, хөгжлийн давуу болон сул талын үнэлгээний талаар бизнес эрхлэгчиддээ мэдээлэл хийж, хувийн хөгжих тааай нөхцөлийг хэрхэн бүрдүүлэх талаар ярилцлага өрнүүлж санал хүсэлтийг нь шийдвэрлэхээр ажиллаж байна. ЭЗХЯ, ҮХААЯ-наас төр хувийн хэвшлийн түншлэл, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх сургалт мэдээллүүд хийлээ.

“Хангайн бүсийн түншлэл Булган -2013” үзэсгэлэн худалдааг Орхон Булган аймгийн ХАУТ-тай хамтран зохион байгуулж, салбарын яамдууд "Сум" төслийн танилцуулга, "Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх", "Сумын нийгмийн үйлчилгээний чиг хандлага", "МУ-ын Үйлдвэржүүлэлтийн бодлого", Оюуны өмчийн газраас орон нутгийн брэндийг "Газар зүйн заалтаар баталгаажуулах" сэдэвт сургалт мэдээллүүдийг зохион байгууллаа.

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**Зорилт 1.10.** Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хэрэглээний аюулгүй байдлыг дээшлүүлэх, хэрэглэгчийг чанартай аюулгүй бүтээгдэхүүнээр хангахад стандартчилал хэмжилзүй, тохирлын үнэлгээгээр дэмжлэг үзүүлэх ажлыг сайжруулна.

Хүрэх үр дүн: Стандартчилал тохирлын үнэлгээ, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хуулийн хэрэгжилт сайжирна.

**1.10.1.** Хэмжүүрийн баталгаажуулалтын эталон тоног төхөөрөмжийн нэр төрөл, хангамжийг сайжруулах **/2013-2016/**

Эзэлхүүн зарцуулалтын лабораторид шатахуун хэмжиж шалган баталгаажуулах 10 литрийн эталон мерник авч ашиглаж байна.

**/Тухайн жил 90 хувь /**



**1.10.5.** Барилгын материалын туршилт сорилын лаборатори байгуулж, боловсон хүчнийг бэлтгэх /2013/

*Барилгын материалын туршилт сорилын лаборатори байгуулахаар 216 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэж, барилгын зураг төслийг боловсрууллаа. Лаброторид хэрэглэгдэх шахагч машин 1 ш, ком шүршүүр 1ш, конусын суулт тодорхойлогч 1 ш, бетон сорьцын хэв 2 ширхэгийг авлаа.*

**/Тухайн жил 50 хувь /  
/Өссөн дүнгээр 12,5 хувь /**

**Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн биеэ даасан тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлнэ.**

**Зорилт 1.11.** Аялал жуулчлалын менежментийг сайжруулж, аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх арга замыг судлан тогтоож, жуулчдын сонирхол, хэрэгцээг хангахуйц арга барилыг нэвтрүүлнэ.

Хүрэх үр дүн: Булган нутагт ирэх жуулчдын тоо нэмэгдэж, ногоон эдийн засгийн хөгжилд бодитой ахиц гарна.

**1.11.1.** Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлж, аялал жуулчлалын салбарын материаллаг баазыг бэхжүүлэх, менежментийг боловсронгуй болгож, жуулчлалын тодорхой чиглэлүүдийг улсын нэгдсэн сүлжээнд оруулах /2013-2016/

*Аймгийн хэмжээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулахтай холбогдуулан Байгалийн болон түүх соёлын , рашаан сувилалын, явган аялал, усан болон спорт ан агнуурын чиглэлээр маршрутуудыг боловсруулан батлуулахад бэлэн болсон.*

**/Тухайн жил 90 хувь/  
/Өссөн дүнгээр 22,5 хувь/**

**1.11.2.** Дотоод, гадаадын жуулчид, анчдыг хүлээн авах стандартын шаардлага хангасан зочид буудал, жуулчны бааз, дэн буудал, мотелын сүлжээг байгуулж, үйл ажиллагааг нь дэмжих /2013-2016/

*Аймгийн засаг даргын Захирамжийн дагуу аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд Аймгийн орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг 16 суманд аялал жуулчлалын чиглэлээр газар олгогдсон 256 иргэн, аж ахуйн нэгжүүдэд стандартын шаардлага ханган ажиллаж буй эсхэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж мэдээллийн сан бүрдүүлэн зөвлөн туслаж, үр дүнг аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж цаашид авах арга хэмжээг төлөвлөн ажиллаа.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**1.11.3.** Сум бүрт жуулчдын сонирхлыг татах малчдын ахуй амьдрал, уламжлалт мэдлэг, соёл иргэншилтэй танилцах зэрэг эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулж, аялал жуулчлалын брэнд үйлчилгээг бий болгох/2013-2016/

*Аймгийн соёл, аялал жуулчлалын эвент албан ёсны 2 арга хэмжээг төлөвлөснөөс Сайхан сумын айрагны баярыг уламжлал ёсоор зохион байгуулж тус арга хэмжээнд аймгийн 16 сумын төлөөлөл, Архангай аймгаас айраг үйлдвэрлэгч*

*иргэд оролцож айрагны зан үйлтэй холбоотой уралдаан тэмцээнийг зохион байгуулж 500 орчим гадаад, дотоодын жуулчид оролцлоо.*

*Сайхан сум Соёлын бренд бүтээгдэхүүн болох “Хөхүүрийн баярыг” 8 сард зохион байгуулж уламжлат ёс заншлаа 100 гаруй гадаад дотоодын жуулчдад сурталчиллаа.*

*ОХУ-ын Буриад улсын Закамень аймагтай хамтран зохион байгуулдаг “Эв модны наадам”-ийг 2014 онд зохион байгуулагдахаар хүлээгдэж байна.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**1.11.4. Байгалийн адал явдалт болон спорт аялал жуулчлалыг дэмжиж, аялал жуулчлалыг төрөлжүүлэн хөгжүүлэх /2013-2016/**

*Байгалийн болон түүх соёлын дурсгалт газруудыг түшиглэн явган болон авто аялалын маршрутыг сум бүрт гарган хэрэгжүүлж байна.*

*“Зэд Хантай Бүтээлийн нуруу”-ны дархан цаазат газарт аялал жуулчлал хөгжүүлэх нөөцийн судалгааг хийж байна.*

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**1.11.5. Аялал жуулчлал, музейн үзмэрүүдээр каталоги, танилцуулга гаргаж, вэб хуудсаар дамжуулан мэдээлэл, сурталчилгаа хийх /2013-2016/**

*Аймгийн түүх соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газруудыг сурталчлах зорилгоор “be Mongolia” төслийн хүрээнд Булган аймгийн байгалийн болон түүх соёлын дурсгалт газруудаар аяласан аялалыг NTV телевизээр цуврал нэвтрүүлэг бэлтгэн гаргалаа.*

*Аймгийн ТСДЗ, байгалийн үзэсгэлэнт газруудын фото альбом гаргахад шаардагдах мэдээллийг ССАЖЯ-ны дэргэдэх Аялал жуулчлалын үндэсний төвд хүргүүлээ.*

*Рашаант сумын тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа орон нутгийн түүхэн домогт газруудын танилцуулга, гарын авлагыг гаргалаа.*

**/Тухайн жил 50 хувь /  
/Өссөн дүнгээр 12.5 хувь /**

**1.11.6. Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлж, гар урчуудын бүтээлийг зах зээлд гаргах маркетингийн асуудлыг шийдвэрлэх /2013-2016/**

*Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчилах зорилгоор сумдад бэлэг дурсгалын дэлгүүрийг нээн ажилуулах санал хүргүүлсэн бөгөөд Хишиг-Өндөр сум орон нутагтаа гар урлал, хүнсний бүтээгдэхүүнээрээ үзэсгэлэн худалдаа зохион байгуулан сурталчилж байна. Сумдад орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, гар урлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор сум хөгжүүлэх сангаас иргэдэд зээл тусламжид хамруулж байна. .*

*Булган аймгийн 16 сум “Хангай бүсийн түншлэл -2013” үзэсгэлэн худалдаанд бренд бүтээгдэхүүнээ сурталчлан амжилттай оролцсон.*

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22.5 хувь /**

**Зорилт 1.12.** Байгалийн үзэсгэлэнт болон түүх, соёлын дурсгалт газар, рашаан сувилал, дэд бүтэц зэрэг давуу талаа түшиглэн аялал жуулчлалын маршрут гаргаж, салбарын үйлчилгээний чанар стандартыг сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

*Хүрэх үр дүн: Байгальдаа ээлтэй, аяллын тав тухтай орчин бүрдэнэ. Аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүнийг бий болгоно.*

**1.12.1.**Өвөрхангай, Архангай, Хөвсгөл аймгийн чиглэлийн зам дагуу аялагчдын түр буудаллаж амрах цэгүүдийг бий болгож, үйлчилгээний чанар стандартыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх/**2013-2016/**

*Хил залгаа аймгуудтай аялалын дайран өнгөрөх 4-н чиглэлийн маршрутыг гаргасан. Аялалын замын түр будаллах цэгүүдийг Хутаг-Өндөр сум, Рашаант сум, Дашинчилэн сумдад тодорхойлон ССАЖЯманд хүргүүлснээр цаашид баригдах түр буудаллах цэгийн улсын хэмжээний төлөвлөгөөнд тусгуулаад байна.*

*Мөн Бүрэгхангай сум ССАЖЯманд түр буудаллах цэгийг орон нутагтаа байгуулах саналыг уламжлан холбогдох мэрэгжилтэнүүд 12 сар ирхээр болоод байна.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**1.12.2.** Хөрш зэргэлдээ улсуудтай аялал жуулчлалын чиглэлээр идэвхитэй хамтран ажиллах, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх/**2013-2016/**

*Хөрш зэргэлдээ улс орнуудтай хамтран ажиллах гэрээний дагуу Солонгос улсын Дүнгү дүүрэг, БНХАУ-ын И Ян мужтай соёлын болон хөдөө аж ахуй, аялал жуулчлалын чиглэлээр хамтран ажиллаж байна.*

**Тухайн жил 50 хувь/  
/Өссөн дүнгээр 12.5 хувь/**

**1.12.3.** Түүхийн үнэт олдвор болох “Шороон бумбагар”, “Цогтын цагаан байшин” зэрэг газруудад музей байгуулж, аялал жуулчлалын сүлжээнд хамруулах/**2013-2016/**

*“Цогтын цагаан байшин”, “Хар бухын балгас”, “Чин толгой”, “Шороон бумбагар” зэрэг түүх соёлын дурсгалт газруудыг холбосон авто аялалын маршрутыг гаргаж Архангай аймагтай холбосон сүлжээнд холбож ССАЖЯ-нд маршрутыг хүргүүлээд байна.*

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22,5 хувь /**

**1.12.4.** Булган сумын “Цагаан суврага”-ыг сэргээн босгох ажлыг дуусгаж, “Диваажин сүм”-ийг босгох ажлыг эхлүүлэх /**2013-2016/**

*Диваажин сүмийн сэргээн засварлах зураг төсөв хийлгэж экспертизээр оруулж, сэргээн засварлахад шаардагдах 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлэхээр ССАЖЯ-нд санал тавиад байна.*

*Цагаан суваргаруу 75,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цахилгааны шугамыг татаж, “Конконсалтинг” ХХК-аар шинэчилсэн зураг төсвийг хийлгэж байна.*

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22,5 хувь /**

**1.12.5.**Могодын “Хулжийн рашаан”, Баян-Агтын “Хануй”, “Цагаан гол”-ын рашаан, Хутаг-Өндөрийн “Их булаг”, Сайхан сумын “Хунт”-ын рашаан болон бусад үзэсгэлэнт газруудыг түшиглэсэн аялал жуулчлалын сүлжээг бий болгох/**2013-2016/**

*“Хулжийн рашаан”, “Хануй”, “Цагаан гол”, “Их булаг”, “Хунт” зэрэг рашаануудыг түшиглэсэн аялалын 5-н маршрутыг боловсруулан гаргасан бөгөөд дээрх нөөцөд тулгуурласан маршрутыг улсын нээгдсэн сүлжээнд оруулах ажил хийгдэж байна.*

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**1.12.6.**Орхон сумын “Сээрийн амралтын газар”-ын бааз суурийг түшиглэн аялал жуулчлалын цогцолбор байгуулах ажлыг дэмжиж, Орхон, Булган сумын ахмадын болон хүүхдийн сувилал болгон өргөжүүлэх/**2013-2016/**

*Орхон сумын “Сээрийн амралтын газар”-ыг үйл ажиллагааг сэргээх зорилгоор 1 га газрыг дуудлага худалдаагаар оруулан иргэнд эзэмшүүлээд байна.*

**/Тухайн жил 30 хувь /  
/Өссөн дүнгээр 10 хувь /**

**Зорилт 1.13.** Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Хүрэх үр дүн: Аялал жуулчлалын салбарын улирлын хамаарлыг багасгана.

**1.13.1.** Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор цогцолбор баазуудыг байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх **/2013-2016/**

*Орон нутгийн хэмжээнд Хангал сумын “Сэлэнгэ” амралт цанын бааз ажиллуулан амрагчид авч байна. Бугат суманд өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 2,5 га газарт цанын бааз байгуулах ажлыг 17,0 сая төгрөгөөр орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр шийдвэрлээд байна.*

*Орхон сумын “Оросын булаг” амралтын газар цанын бааз ажиллуулахаар тохижилтын ажилуудыг хийгдэж байна.*

*Бүрэгхангай суманд цас, мөсний баярыг зохион байгуулах зорилгоор зориулалтын байрыг тохижуулан ажиллаж байна.*

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**1.13.2.** Аялал жуулчлалын салбарыг зарим өвлийн спорт, уламжлалт соёлын арга хэмжээтэй уялдуулан хөгжүүлэх бодлого чиглэл гарган ажиллах **/2013-2016/**

*Сэлэнгэ суманд “Мөсний баяр”, Бугат суманд “Цасны баяр” зэрэг арга хэмжээнүүдийг уламжлалт соёлын арга хэмжээнүүдтэй уялдуулан 2014 оноос уламжлал болгон зохион*

*байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.*

*Хутаг-Өндөр, Бугат, Бүрэгхангай, Орхон, Могод, Хишиг-Өндөр, Хангал, Хялганат зэрэг өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.*

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**Дэд бүтцийн салбарт:**

Хот байгуулалт, дэд бүтцийн салбарын хөгжлийг эрчимжүүлж эрүүл аюулгүй тав тухтай амьдрах орчинг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

**Зорилт 1.14.** Улсын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээг сайжруулж, “Мянганы зам”-ын хэвтээ тэнхлэгийн замын ажлыг дуусгаж, аймаг, сумдын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулна.

Хүрэх үр дүн: Аймгийн авто замын урт нэмэгдэж, авто зам, замын байгууламжийн нөхцөл, нийтийн тээврийн үйлчилгээ сайжирч, замын хөдөлгөөний аюулгүй байдал дээшилнэ.

**1.14.1.** Уньт-Хутаг-Өндөр-Намнангийн ар хүртэлхи чиглэлийн 88 км хатуу хучилттай авто замыг барьж дуусгах/**2013-2015/**

Уньт-Хутаг-Өндөр-Намнан чиглэлийн хатуу хучилттай замын гүйцэтгэгчээр БНСУ-ын “Бэк сок констракшн” ХХК ажиллана. *Óã çàì ùí àæëë 2012 îí ù 04 дүгээр ãàðààñ ýõýëсэн бөгөөд 2014 îí ù 08 дугаар ãàðä äóóõããàðàä äýäýýí ä ò óãããããñàí . Монгол улсын Ерөнхий сайд Алтанхуяг авто зам, замын байгууламжийн ажилтай танилцан 2013 оны 11 сард хүлээлгэн өгөх үүрэг даалгавар өгөв.*

Орон нутгаас элс, хайрга, даланд ашиглагдах материалын карьер ашиглуулах асуудлаар АЗДТГ-ын ХБХ-ийн дарга, ТАЗГ-ын дарга, БОГ-ын мэргэжилтэн нар газар дээр нь ажиллаж асуудлыг шийдвэрлэсэн.

Нийт төсөвт өртөг 33486.7 мянган ам доллар ба 2013 оны эхний 6 сарын байдлаар 8260.4 сая төгрөг, 2863.9 мянган ам долларын санхүүжилт олгогдсон байна.

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 70 хувь /**

**1.14.2.** Сэлэнгэ мөрнийг гатлах явган зорчигчийн 2 хэсэг 422,5 метр урттай гүүрийг үргэлжлүүлэн барьж, ашиглалтад оруулах/**2013-2014/**

Сэлэнгэ мөрнийг гатлах явган зорчигчийн гүүрийг үргэлжлүүлэн барьж байгаа бөгөөд 2843.0 сая төгрөгийн ажил хийгдэхээс 1093.0 сая төгрөгийн ажил хийгдсэн. Ажлын гүйцэтгэл 38.6 хувьтай.

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 45 хувь /**

**1.14.3.** Сайхан-Могод сумыг холбосон Орхон голын “Сөрдөг гарам” орчимд төмөр бетон гүүр барих/**2013-2016/**

Орхон гол дээр гүүр барих газрын байршлыг тогтоож, зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, бэлэн болгосон.

Гүүр барихад шаардагдах 5.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр Зам, тээврийн яам, Эдийн засгийн хөгжлийн яаманд хүсэлт тавьсан.

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**1.14.4.** Нутгийн удирдлагын ордны дэргэдэх авто машины 2240 м2 зогсоол, 116.55 метр хатуу хучилттай авто замыг барих **/2013/**

*Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар авто машины зогсоол, хатуу хучилттай авто зам барихаар төлөвлөсөн боловч Нутгийн удирдлагын ордны барилга угсралтын ажил дуусаагүй, Булган сумыг “Булган хот” болгох болдого баримтлан автомашины зогсоол, авто замын зураг төсвийг өөрчлөх, шинээр авто зам барихаар ажлын даалгавар, тойм зураг боловсруулагдаж байгаатай холбогдуулан 2014 онд гүйцэтгэхээр хойшлуулсан.*

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**1.14.5.** Булган сумын 3 дугаар багийн 12 дугаар гудамжнаас А1002 улсын чанартай авто зам хүртэл 1.8 км хатуу хучилттай авто зам барих/**2013/**

*1.8 км хатуу хучилттай авто зам барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, авто замын далан, хучилтын ажил хийгдэж дууссан. Ажлын явц 80.0 хувьтай.*

**/ Тухайн жил 80 хувь /  
/Өссөн дүнгээр 80 хувь /**

**1.14.6.** Булган сумын “Зүүн түрүү” чиглэлийн 3 км хатуу хучилттай авто замын үлдсэн хэсэг болох 1,8 км авто замыг үргэлжлүүлэн барих **/2013-2014/**

*Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2012, 2013 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад тусгагдсаны дагуу 1.240 км хатуу хучилттай авто замын далан, хучилтын ажил дууссан. Ажлын явц 80 хувьтай байна.*

*Улсын төсвийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад тусгуулах саналаа Зам, тээврийн яам, Эдийн засгийн хөгжлийн яаманд албан бичгээр хүсэлт тавьсан.*

**/Тухайн жил 80 хувь /  
/Өссөн дүнгээр 20 хувь /**

**1.14.7.** Булган сумын 5 дугаар багийн А-Б хэсгийн хоорондох 0,7 км хатуу хучилттай авто замыг барих **/2013/**

*2013 оны орон нутгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 0,7 км хатуу хучилттай авто зам барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, авто замын далан, хучилтын ажил дууссан. Ажлын явц 80 хувьтай.*

**/Тухайн жил 80 хувь /  
/Өссөн дүнгээр 80 хувь /**

**1.14.8.** Татварын хэлтсийн зүүн талд 560,26 м<sup>2</sup> авто машины зогсоол, 14 м хатуу хучилттай авто замын гарц байгуулах **/2013/**

*Орон нутгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар Татварын хэлтсийн зүүн талд авто машины зогсоол, хатуу хучилттай авто замын гарц байгуулав.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 100 хувь /**

**1.14.9.** Булган сумын Зүүн түрүүний модон гүүрийг төмөр бетонон гүүр болгон шинэчлэх /2013-2016/

*Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Зүүн түрүүний модон гүүрийг төмөр бетонон гүүр болгон шинэчлэх ажлын зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж байна. Зураг төсвийн ажлын явц 80 хувьтай байна.*

**/Тухайн жил 80 хувь /  
/Өссөн дүнгээр 20 хувь /**

**1.14.10.** Баян-Агт сумын “Хануй” голын “Ангархай”-н авто замыг засварлах /2013-2014/

*Баян-Агт сумын “Хануй” голын “Ангархай”-н авто замыг засварлах ажлын зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.*

*Улсын төсвийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад тусгуулах саналаа Зам, тээврийн яам, Эдийн засгийн хөгжлийн яаманд албан бичгээр хүсэлт тавьсан.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**1.14.11.** Аймгийн төвийг сумдын төвтэй холбосон орон нутгийн чанартай авто замын засвар, шинэчлэлийн ажлыг ээлж дараатайгаар гүйцэтгэх/2013-2016/

*Орон нутгийн авто замын сангийн 15.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайхан, Хишиг-Өндөр, Орхон сумдын авто замыг засварлах ажлын эрхийг сумын Засаг дарга нарт шилжүүлж, замын ажлыг гүйцэтгүүлэв.*

**1.26.1.**Төсвийн төсөл боловсруулах, түүнийг хэлэлцэж батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, хянаж үнэлэх шатанд иргэд олон нийтийн оролцоог хангаж ажиллах **/2013-2016/**

Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2012 оны төсвийн гүйцэтгэлийг аймгийн ИТХ-ийн ээлжит хуралдаанаар иргэдэд нээлттэй хэлэлцүүлж батлуулсан. “Төсвийн тухай” хуулийг хэрэгжүүлж 2014 оны аймгийн ОНХСанаар хэрэгжих төсөл арга хэмжээний саналыг сумдад нээлттэй хэлэлцүүлэн санал авч аймгийн ЗДЗ, ИТХ-д хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Аймгийн 2013 оны батлагдсан төсөв, хурлын тогтоол, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ зэргийг аймгийн [www.bulgan.gov.mn](http://www.bulgan.gov.mn) вэб сайт, Булганы мэдээ сонин, Шинэ Булган мэдээллийн эмхэтгэлд байршуулан иргэд олон нийтэд хүргэж байна.

**/Тухайн жил 80 хувь/  
/Өссөн дүнгээр 20 хувь/**

**1.26.2.**Төсвийн төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн систем нэвтрүүлэх **/2013-2016/**

*Төсвийн шинэчлэлийн 2 дахь шатны хүрээнд бүх шатны төсөв боловсруулах, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналтыг төсвийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлэх зорилт тавин “Төсвийн төлөвлөлтийн удирдлага мэдээллийн систем /PBIS”-ийг Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газарт боловсруулж байна. Тус програм хангамжийн эхлэл болгон Төсвийн төлөвлөлтийн FISCAL программ хангамжид 2013 оны батлагдсан төсвийн төлөвлөгөө, 2012 оны төсвийн гүйцэтгэлийн хамт шивж орууллаа.*

*Орон нутгийн хөгжлийн сангийн системийн сургалтыг санхүүгийн хэлтэс, сумдын төрийн сангийн төлөөлөгчдөд хийж, тус сангаас хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний явцыг бүрэн хянах боломж бүрдлээ.*

**/Тухайн жил 50 хувь/  
/Өссөн дүнгээр 12.5 хувь/**

**1.26.3.**Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх **/2013-2016/**

*Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн Ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн Дотоод аудитын албыг байгуулж ажиллуулахаар хуульчлагдсан. Өнөөдрийн байдлаар аймгийн ЗДТГ-ын бүтэц орон тоо, төсөв батлагдаж ирээгүй учраас Дотоод аудитын албыг байгуулаагүй байна.*

**/Тухайн жил 10,0 хувь/  
/Өссөн дүнгээр 0.0 хувь/**

**1.26.4.**Тендер шалгаруулалтын ил тод байдлыг хангаж, худалдан авах ажиллагааны хуулийн хүрээнд цахим худалдан авах ажиллагааг шат дараатай нэвтрүүлэх/**2013-2016/**

*Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор аймгийн Засаг даргаар батлагдсан тухайн жилийн төлөвлөгөө, түүнд үндэслэсэн гүйцэтгэлийн мэдээ тайлан, НТШ журмаар болон хуульд заасан бусад аргаар зохион байгуулагдаж байгаа тендерийн зарыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас [www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn), Булган аймгийн цахим хуудас [www.bulgan.gov.mn](http://www.bulgan.gov.mn) хаягаар нийтлэхийн зэрэгцээ Монголын өдөр тутмын сонин хэвлэлүүдэд тухай бүр нь тогтмол хэвлэн мэдээлж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу ИТХ-аас томилсон иргэдийг үнэлгээний хороонд тогтмол оролцуулан ажиллаж байна.*

*Сангийн сайдын 2013 оны 01 сарын 11-ний өдрийн 01 тоот тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах”, 2013 оны 04 сарын 19-ний өдрийн 84 дүгээр тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалтын урилга, үр дүнг нийтлэх” журмын дагуу худалдан авах ажиллагааны тухайн жилд батлагдсан төсөл арга хэмжээний 20-ээс доошгүй хувийг цахим худалдан худалдан авах ажиллагаагаар зохион байгуулахаар бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.*

**/Тухайн жил 50 хувь/  
/Өссөн дүнгээр 12.5 хувь/**

**1.26.5.**Худалдан авах ажиллагааг бие даасан алба байгуулах **/2013-2016/**

*“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу Засгийн газрын 2012 оны 144 дүгээр тогтоолоор Худалдан авах ажиллагааны албыг аймгийн Засаг даргын дэргэд 4 орон тоотойгоор байгуулж, үйл ажиллагааны зардлыг 72,8 сая төгрөгөөр тооцож орон нутгийн төсөвт тусгаж баталлаа.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 100 хувь/**

**Зорилт 1.27.** Нягтлан бодох бүртгэл, аудит, дотоод хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл хөтлөлт, тайлан гаргалтыг сайжруулах замаар төсвийн орлогын бүрдүүлэлт, зарлагын хэмнэлтэнд эерэг нөлөө үзүүлэх, бvх шатны удирдлагад санхүү, эдийн засгийн оновчтой шийдвэр гаргахад арга зvй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

*Хүрэх үр дүн: Нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сайжирсан байна.*

**1.27.1.**Аж ахуйн нэгжид нягтлан бодох бүртгэлийн хуулийн хэрэгжилтийг хангуулж, бүртгэлийн ажилтнуудын боловсролын түвшинг ахиулах/**2013-2016/**

*Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу аж ахуйн нэгжийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 666 байгууллагаас хүлээн авч 93.1 хувийг хамрууллаа. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох сургалт шалгалтыг зохион*

байгуулж 28 нягтлан бодогч хамруулан 8 хүн хөнгөлөлт авч, 1 мэргэшсэн нягтлан бодогчтой боллоо. Нягтлан бодох бүртгэлийг хөгжүүлэх сантай хамтран хувийн хэвшлийн 127 аж ахуйн нэгж байгууллагын захирал нягтлан бодогч нарт санхүүгийн тайлан гаргалт олон улсын стандарт нэвтрэлтийн талаар 2 өдрийн сургалт зохион байгуулж сертификат олголоо.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**1.27.2.Нягтлан бодох бүртгэлийн стандартын нэвтрэлтийг эрчимжүүлэх/2013-2016/**

Сангийн сайдын 2012 оны 75 тушаалаар батлагдсан улирал, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн А, Б маягыг хэвлүүлж аж ахуйн нэгжид хүргүүллээ. Шинэчлэгдсэн нягтлан бодох бүртгэлийн “И-Баланс” программд 2012 оны жилийн эцсийн үлдэгдлийг шивж орууллаа. 3-р улирлын 482 ААНБ-ын санхүүгийн тайланг хүлээн авч, Сангийн яаманд интернэтээр дамжууллаа. Санхүүгийн маягт зааваар журмын талаар аж ахуйн нэгж, байгууллагад зааварчлага өгч ажиллаа.

**/Тухайн жил 50,0 хувь/  
/Өссөн дүнгээр 12,5 хувь/**

**1.27.3.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл мэдээллийн нэгдсэн баазыг ашиглан хөрөнгийн ашиглалт зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг хангах/2013-2016/**

Орон нутгийн өмчит 16 сум 1 тосгоны 168 байгууллагын хөрөнгийн тооллогын материалыг хүлээн авч санхүүгийн тайлантай тулгаж нэгтгэснээр 118,8 тэрбум төгрөгийн хөрөнгө тоологдсон нь өмнөх оноос 18,4 тэрбум буюу 18,3 хувиар өсчээ. Эхний хагас жилийн байдлаар орон нутгийн өмчит байгууллагаас хөрөнгө худалдаж авах, актлах, дуудлага худалдаагаар оруулах зэрэг саналыг судлан аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 14 удаагийн хурлаар давхардсан тоогоор 78 байгууллагын 840.0 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэлээ. Үүнээс 37.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэн, 67.0 сая төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан, 715.3 сая төгрөгийн балансаас балансад шилжүүлж, 20.7 сая төгрөгийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг тооцож ажиллаж байна.

ТӨХ “Тауэрсофт” ХХК-тай хамтран орон даяар төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн систем бүхий программ хангамжийг “онлайн”-аар ашиглах боломжийг бүрдүүлэн үнэ төлбөргүй ашиглуулахаар шийдвэрлэсэн. Тус мэдээллийн системд орон нутгийн өмчит 168 байгууллага, төрийн өмчит 25 байгууллага хамрагдахаар боллоо.

**/Тухайн жил 80 хувь/  
/Өссөн дүнгээр 20 хувь/**

**1.27.4.Санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн системд зарим төсвийн байгууллагыг холбож, төрийн сангийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх /2013-2016/**

Төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийг бүрэн нэвтрүүлж, улирал, жилийн санхүүгийн тайланг Төрийн сангийн нэгтгэлийн Plastic програмд электрон файлаар 17 сумын нэгдсэн тайлан болон шууд харъяа байгууллагын тайланг хүлээж авч нэгтгэн Сангийн яаманд электрон файлаар хуулийн хугацаанд хүргүүлээ. Төрийн сангийн үйлчилгээ авч буй төсвийн байгууллага нь “Онлайн тайлан”-гийн системийг ашиглаж төсвийн хөрөнгийг үр ашигтай удирдах боломжийг олгоод байна.

**/Тухайн жил 30 хувь/  
/Өссөн дүнгээр 10 хувь/**

**1.27.5.**Төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг ханган ажиллах **/2013-2016/**

Санхүү төрийн сангийн хэлтэс нь орон тоондоо багтаан төрийн сангийн дотоод хяналт хариуцсан ажилтанг томилон Сангийн яамнаас зохион байгуулсан сургалтад хамрууллаа. Төрийн сангийн төлбөр тооцоог өдөр тутам хянаснаар орлогын дансны үлдэгдлээс хэтрүүлж санхүүжилт хийсэн Булган, Орхон, Сайхан, Хутаг-Өндөр сумын алдааг залрууллаа.

**/Тухайн жил 50 хувь/  
/Өссөн дүнгээр 12.5 хувь/**

**Зорилт 1.28.** Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, бодлогын удирдамжаар хангана.

Хүрэх үр дүн: Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх бодлогын удирдамжаар хангаж ажилласан байна.

**1.28.1.**Арилжааны даатгалын компаниудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд учирч болох эрсдэлийг бууруулах, даатгалын ач холбогдлыг сурталчлан даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх ажлыг өргөжүүлэх**/2013-2016/**

Тус аймагт Монгол даатгал, Номин даатгал, Практикал даатгал, Миг даатгал, Ард даатгал, Бодь даатгал, Тэнгэр даатгал, Хаан даатгал, Соёмбо даатгалын салбарууд ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар тус даатгалын салбарууд гэнэтийн осол, эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын даатгал зэрэг төрлүүдээр даатгалын үйлчилгээ үзүүлж 3609 иргэн, 286 хуулийн этгээдийг хамруулан 114,8 сая төгрөгийн орлого орж өмнөх оноос 2,6 дахин өсч, иргэн, хуулийн этгээдэд 12,3 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна. Санхүүгийн зохицуулах хороо, Албан журмын даатгаагчдын холбоотой хамтран сургалт зохион байгуулсан. Албан журмын даатгаагчдын холбооны орон нутаг хариуцсан менежерийг томилуулж, сургалтад хамруулан үйл ажиллагааг нь эхлүүллээ. Тус салбар нь аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг болон даатгалын компаниудтай хамтран аймгийн хэмжээнд “Жолоочийн даатгалын тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулах сарын аяныг зарлан ажиллаж байна.

**/Тухайн жил 100,0 хувь/  
/Өссөн дүнгээр 25,0 хувь/**

**1.28.2.**Брокерын компани, бичил санхүүгийн /банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо/ үйл ажиллагааг дэмжиж ажиллах /2013-2016/

*Тус аймагт Булган брокерын пүүс үйл ажиллагаагаа явуулж байна. Тус брокерт 13557 данс эзэмшигч байгаа бөгөөд үүний 1089 нь Таван толгой ХК-ны хувьцаа эзэмшигч байна.Энэ онд 50 ХК-ны 120,0 мянган хувьцаа борлууллаа.Хувьцааны ногдол ашгийн мэдээлэл, тархалтын судалгаа, үнэт цаасны арилжааны мэдээлэл хангалтгүй байна. Хас банкны Булган салбартай хамтран ажиллаж Хутаг-Өндөр суманд “Хан намнан хөгжил” ХЗХ, Гурванбулаг суманд “Хөгнөхон хөгжил” ХЗХ, Дашинчилэн суманд “Цогтын хишиг” ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа ба гишүүдийн тоо өсч зээлийн багцын чанар сайжран үйл ажиллагаа тогтмолжоод байна. НББ-ын Genus программыг нэвтрүүлэн санхүүгийн тайланг Санхүүгийн зохицуулах хороонд хүргэлээ. Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дүнг ХЗХ-д хүргүүлж, үр дүнд дүгнэлт хийж ажиллах чиглэл өгч ажиллаа.*

**/Тухайн жил 70,0 хувь/  
/Өссөн дүнгээр 17.5 хувь/**

**Зорилт 1.29.** Статистикийн үйл ажиллагааны хараат бус бие даасан байдлыг бэхжүүлж, албан ёсны статистикийн мэдээ мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгож, үнэн бодит шуурхай, ил тод байдлыг хангана.

Хүрэх үр дүн:Статистикийн хараат бус, бие даасан байдал хангагдаж, мэдээллийн түгээлт, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.

**1.29.1.**“Монгол улсын статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж аймгийн мастер төлөвлөгөөг батлуулах /2013-2016/

*“Монгол улсын статитсикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг аймгийн ИТХурлын тэргүүлэгчдийн 2013 оны 06-р сарын 12 өдрийн хурлаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 50 хувь /**

**1.29.2.**Хүн амын статистикийн бүртгэл мэдээллийн сангийн бүрдүүлэлт, ашиглалтыг сайжруулан түүвэр судалгааны төрлийг нэмэгдүүлэх/2013-2016/

*Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг, Сэлэнгэ, Хангал, Хялганат, Булган сумдын Хүн Амын Өрхийн Бүртгэлийн дэвтэр хөтлөлт, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, ашиглалтад хяналт шалгалт хийж, бүх сумдын ХАӨБ-ийн дэвтрийн программыг дахин шинээр компьютерт суулган ашиглалтыг сайжруулан ажиллаж байна. Дээрх сумдуудад хийсэн шалгалтаар гарсан нийтлэг алдаа болон, бусад алдаа дутагдлыг тухай бүр нь газар дээр нь засуулж, зарим дутагдлыг бүрэн арилгах хугацаатай үүрэг даалгавар өгөн ажиллалаа. ХАӨБД-ийн зурагжуулалт, хаягын хэсэг, баталгуужуулалт хангалтгүй байсан Баяннуур сумын 2 баг, Хангал сумын 4 баг, Булган сумын 1-р багийн Засаг даргад хугацаатай үүрэг даалгавар өгсөн. 2013 оны жилийн эцсийн “Хүн амын, өрх”-ийн мэдээ тайланг ХАӨБ-ийн мэдээллээс шууд авахаар*

бэлтгэл ажлыг ханган сургалт семинарыг 2013 оны 11-р сарын 22 нд хийхээр төлөвлөн ажиллаж байна. Энэ ажлын үр дүнд ХАӨБүртгэлээс жилийн эцсийн хүн амын холбогдолтой бүх мэдээлэлийг гарган дүн шинжилгээ хийн хэрэглэгчдэд тархаан, Мөн шат шатны хяналтыг хийснээр хүн амын давхардал, хаягын давхардал арилна. 2013 ондоо багтаан үлдсэн сумдад ХАӨБДэвтэр, мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд хийх хяналт шалгалтыг бүрэн хийж дуусна.

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22,5 хувь /**

**1.29.3.Статистик мэдээний хүрээг өргөжүүлж, түгээлт, хүртээмжийг сайжруулах/2013-2016/**

Статистикийн албан ёсны болон захиргааны мэдээллийг хүрээг өргөжүүлэх анхан шатны нэгжийн мэдээний хамралтыг сайжруулах зорилгоор мэргэжилтэн бүр салбар бүрийн тайлан мэдээнд ирц хөтлөн, шинээр бий болсон аж ахуйн нэгжийг тухай бүр нь мэдээнд хамруулах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Албан ёсны болон захиргааны мэдээллийн чанарыг сайжруулах зорилгоор төрийн байгууллагуудын саналыг аван ажиллаж байна. Авсан саналаа нэгтгэн хэрэглэгчдэд хэрэгтэй байгаа мэдээллийг сар бүрийн танилцуулгад гарган мэдээлж байна.

**/Тухайн жил 80 хувь /  
/Өссөн дүнгээр 50 хувь/**

## **ХОЁР. ЭРҮҮЛ ЧИЙРЭГ БУЛГАНЧУУД**

Нийгмийн эрүүл мэнд давамгайлсан эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

**Зорилт 2.30.** Нэгдсэн эмнэлгийг орчин үеийн оношлогооны төв болгож, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, телемедицины Үндэсний сүлжээнд холбоно.

Хүрэхүрдүн: Нэгдсэн эмнэлгийн хоног болоогүй нас баралтыг 20,0-оос доошгүй хувиар бууруулсан байна.

**2.30.1.**Орчин үеийн оношлогооны төвтэй болгож, эмчилгээ оношлогооны болон эх хүүхдийн эрүүл мэндэд нэн шаардлагатай өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /компьютер-томограф, 3, 4D эхосонографи, тархины цахилгаан бичлэг, суурин болон зөөврийн дижитал флюорографи аппаратууд, шүдний борын иж бүрдэл, иж бүрэн тоноглогдсон явуулын амбулаторын үйлчилгээний автомашин/-ээр хангаж Телемедицины Үндэсний сүлжээнд холбон, сумдад телемедицины сүлжээг оруулах **/2013-2014/**

Эрүүл мэндийн салбарын тогтолцооны шинэчлэлийн ажлын хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийг орчин үеийн оношлогооны төв болгох зорилгоор бүтэц зохион байгуулалтын шинэчлэл хийх бэлтгэлийг ханган, 2.0 тэрбум төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтанд тусгуулсан болно.

*Нэгдсэн эмнэлгийн Шүдний кабинет, Сэтгэц наркологийн тасаг, Яаралтай тусламж, Төрөх, эмэгтэйчүүдийн тасагт нэн шаардлагатай 323,4 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан.*

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**2.30.2.** “Нарийн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээ үзүүлэх нүүдлийн баг”-ийг байгуулан сум, багт улирлын чанартай ажиллуулах **/2013-2016/**

*Орон нутагт нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэг, тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг аймгийн “Засаг даргын нэрэмжит нүүдлийн амбулатори” хэлбэрээр зохион байгуулж, үзлэгийн график, төлөвлөгөөг боловсруулан, хуваарийн дагуу Бугат, Хутаг-Өндөр, Сайхан, Бүрэгхангай зэрэг сумдын 698 иргэдэд дотор, мэдрэл, эмэгтэйчүүд, шүд, эхо, хүүхдийн чиглэлээр оношлогоо, эмчилгээ хийлээ. Үүнээс 314 иргэдэд эхо үзлэг, шинжилгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.*

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22,5 хувь /**

**2.30.3.** Гэмтлийн тасаг, физик эмчилгээ-нөхөн сэргээлтийн төв, сэтгэцийн эмгэг архи дан согтуурахтай тэмцэх кабинетыг байгуулан шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах **/2013-2016/**

*Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Гэмтлийн кабинет байгуулан гэмтлийн эмч орон тоогоор, мэс заслын тасагт 1 эмчийг гэмтлийн чиглэлээр ажиллуулж байна.*

*Нэгдсэн эмнэлгийн Сэтгэц наркологийн тасгийг ЭМД сангаас 3,4 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, тасгийн тохижилтод зориулсан хэрэгслээр хангаж, эмчлүүлэгчид ээлтэй орчинг бүрдүүлсэн.*

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22.5 хувь /**

**2.30.4.** Эмнэлгийн яаралтай тусламж, хүлээн авах тасгийг стандартын дагуу зохион байгуулан шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах **/2013-2014/**

*Эрүүл мэндийн сайдын 2012 оны 375-р тушаалын дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн Яаралтай тусламж, хүлээн авах тасгийн стандартын хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, өрөө тасалгааг тохижуулсан.*

*Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Яаралтай тусламж, хүлээн авах тасаг 20 нэр төрлийн 38 ш, 82,7 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдлаа.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**2.30.5.** Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хөгжлийн төв байгуулж, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах **/2013-2016/**

*2013 оны эхний 10 сарын байдлаар Эрүүл мэндийн яам болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан эмнэлгийн мэргэжилтний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх 80 төрлийн сургалтанд 347 мэргэжилтэн хамрагдаж мэдлэг ур чадвараа дээшлүүлээд байна.*

*Эрүүл мэндийн газраас эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадваржуулах дотоодын сургалтыг 16 сэдвээр зохион байгуулж, 610 Эрүүл мэндийн ажилтаныг хамруулаад байна*

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22.5 хувь /**

**Зорилт 2.31.** Сум, өрхийн ЭМТ-ийг боловсон хүчин, оношлогоо-эмчилгээний нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хийнэ.

Хүрэх үр дүн: СДЭ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн стандарт хангалтыг 93.0 хувьд хүргэнэ.

**2.31.1.** СДЭ, сум, өрхийн ЭМТ-дийг оношлогоо-эмчилгээний орчин үеийн тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах, эхний ээлжинд дижитал эхо, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, лабораторийн шинжилгээний иж бүрдлээр, СДЭ-ийг дижитал рентген аппаратаар хангах **/2013-2016/**

*Сумдын Эрүүл мэндийн төвүүдийг Япон улсын биохимийн анализатароор хангаж, ЭМТ-ийн дарга, лаборант нарын оношлогооны чадавхийг сайжруулах сургалтад хамрагдсан.*

*Сумын Эрүүл мэндийн төвүүдийг биохимийн анализатороор хангасанаар анхан шатны эмнэлгээр иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээнд чанарын ахиц гарлаа.*

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**2.31.2.** СДЭ, сум, өрхийн ЭМТ-д “Яаралтай тусламж үйлчилгээний нэгж”-ийг байгуулах **/2013-2016/**

*Анхан шатны Эрүүл мэндийн байгууллагуудад “Яаралтай тусламж үйлчилгээний нэгж”-ийг Эрүүл мэндийн сайдын 2012 оны 375-р тушаалын дагуу зохион байгуулж, хүлээн авах хэсэгт эрэмблэн ангилах самбарыг байршуулсан.*

*Яаралтай тусламж үйлчилгээний нэгжид алсын болон яаралтай тусламжийн дуудлагын цүнх, биксийг байрлуулан бэлэн байдлыг ханган ажиллаж байна.*

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**2.31.3.** Багийн хөгжлийн төвд хүний бага эмчийн ажлын өрөөг бий болгож, зайлшгүй шаардлагатай эм, тоног төхөөрөмжөөр хангах **/2013-2016/**

*Багийн эмчид шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг нэгтгэн гаргасан ба Булган сумын багийн хөгжлийн төвд 1 их эмч, сувилагчийг ажиллуулж байна.*

*Сумдын багийн эмч нар эмийн эргэлтийн сантай хамтын ажиллагааны гэрээ байгуулан гэрээний дагуу хүн амыг зайлшгүй шаардлагатай эмээр үйлчилж байна.*

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**2.31.4.** АНЭ, бүх сумдын Эрүүл мэндийн төвүүдэд стандартын шаардлага хангасан цогцос хадгалах өрөө /морг/ барих, засварлах, шаардлагатай тоног, төхөөрөмжөөр хангах **/2013-2016/**

*Аймгийн Нэгдсэн эмнэлгийн цогцос хадгалах өрөөг шинэчлэх зураг төсвийн дагуу сэргээн засварлаж, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргасан.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**2.31.5.** Өрхийн ЭМТ-ийг их эмч, эмнэлгийн мэргэжилтнээр бүрэн хангаж, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, унаажуулах **/2013-2016/**

*Булган суманд үйл ажиллагаа явуулж буй Өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн их эмчийн хангалт 100% , эмнэлгийн мэргэжилтний хангалт 100 хувьтай байна.*

2013 онд өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн төсөв 13,1 сая төгрөгөөр батлагдан ирсэн нь өмнөх оныхоос 36915 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

2010 онд “Булган Энэбиш сан”-гийн дэмжлэгээр өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд автомашин олсгосон.

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22.5 хувь /**

**Зорилт 2.32.** Эх, нялхасын эндэгдэл, сүрьеэ, бруцеллёз, халдварт шар, БЗДХӨ-ийг тууштай бууруулж, хувийн эрүүл мэндийн байгууллагын өрсөлдөөнийг бий болгож, үйл ажиллагааг дэмжин бүх шатанд эмчилгээ оношлогоог чанаржуулна.

Хүрэх үр дүн: Эхийн эндэгдэлгүй ажиллаж, нялхасын эндэгдэл, сүрьеэ, бруцеллёз, халдварт шар, БЗДХӨ-ийг улсын дундажаас бууруулна.

**2.32.1** “Эх нярайн эрүүл мэнд” аймгийн стратеги төлөвлөгөө /2013-2016/-г хэрэгжүүлэх

“Эх нярайн эрүүл мэнд” аймгийн стратегийг хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**2.32.2** Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг жил бүр нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулах. / 2013-2016/

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн дийлэнх хувь нь ямар нэг эрхтэн тогтолцооны өвчлөлтэй байгаа нь эхийн эндэгдлийн шалтгаан болж байна.

Орон нутагт амьдарч байгаа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд “Нүүдлийн эмнэлэг”-ээр дамжуулан нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээг зохион байгуулж, нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлттэй холбоотой сургалт сурталчилгааг зохион байгуулж 100 гаруй эмэгтэйчүүдийг хамрууллаа.

Хөхний эмнэлзүйн шинжилгээнд 2906 эмэгтэй, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 2864 эмэгтэйг хамруулж, хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн 3280 эмэгтэйгээс 88,5%-ийг хамруулан, өвчтэй илэрсэн эмэгтэйчүүдийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулж байна.

Аймгийн хэмжээнд “Охид” үзлэгийг зохион байгуулж, нийт 1257 охидыг үзлэг шинжилгээнд хамруулан, өвчтэй илэрсэн 13 хүүхдийг эмчлэн, эрүүлжүүлсэн.

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22.5 хувь /**

**2.32.3** Эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтанд хамруулах / 2013-2016/

2013 оны эхний хагас 10 сарын байдлаар эх барих, эмэгтэйчүүд хүүхдийн чиглэлээр 10 мэргэжилтнийг мэргэжил дээшлүүлэх сургалтанд төрийн санхүүжилтээр суралцуулж байна.

Энэ оны 4-р улиралд Эх нялхасын эрүүл мэндийн төвтэй хамтран ажлын байрны сургалтыг “Нярайн тусламж үйлчилгээ” сэдвэр зохион байгуулж 25 мэргэжилтнийг хамруулахаар бэлтгэлийг хангаад байна.

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**



үзүүлэх ээлтэй орчинг бүрдүүлэхэд анхаарч, дотоод тохижилт хийж, магадлан итгэмжлэлд амжилттай хамрагдлаа.

ХХЭ-үүдийн эмч, мэргэжилтнүүд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд нийт 100 гаруй иргэдийг хамруулан ажиллаж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд оролцоогоо нэмэгдүүлэн ажиллаж байна.

**/Тухайн жил 90.0 хувь /  
/Өссөн дүнгээр 22.5 хувь /**

**2.32.8** Уламжлалт анагаах ухаан нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээг орчин үеийн багаж тоног төхөөрөмжөөр хангах **/2013-2016/**

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн уламжлалт анагаах ухаан нөхөн сэргээх тасагт хэргэцээтэй эмчилгээний тоног төхөөрөмжийн судалгааг орон нутгийн хөгжлийн сан хөтөлбөрт 80.0 сая төгрөгийн төсвийн санхүүжилттэй төсөл хүргүүлэн ажиллаж байна.

**/Тухайн жил 50 хувь /  
/Өссөн дүнгээр 12.5 хувь /**

**2.32.9** Сувилахуйн тусламж үйлчилгээний удирдамжийг хэрэгжүүлж, “Гэрээр үйлчлэх баг”-ийг байгуулж, гэрийн асаргааг хөгжүүлэх. **/2013-2016/**

Аймгийн хэмжээнд гэрийн сувилахуйн тусламж үйлчилгээг ерөнхий болон төрөлжүүлсэн хэлбэрээр үзүүлэн, асаргааны иж бүрдлүүдийг бэлтгэн тусламж үзүүлж байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Сувилгааны алба”, Дашинчилэн, Хялганат, Сэлэнгэ, Баян-Агт сумын Эрүүл мэндийн төвүүд, Хутаг-Өндөр сумын сум дундын эмнэлэг “Гэрээр үйлчлэх сувилахуйн баг”-ийг байгуулан, архаг хууч өвчтэй, ганц бие, өндөр настан нийт 42 хүнд гэрийн сувилахуйн тусламжийг үзүүлсэн байна.

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22.5 хувь /**

**2.32.10** “Архи тамхины шалтгааныг судлах эмнэл зүйн кабинет”-ийг байгуулж, мэдээлэл сургалт сурталчилгаа, эмчлэн эрүүлжүүлэх, олон нийтийн оролцоотой нэгдсэн үйл ажиллагаа явуулах **/2013-2016/**

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Сэтгэц наркологийн тасгийн үйл ажиллагаан дээр түшиглэн “Архи тамхины шалтгааныг судлах эмнэл зүйн кабинет”-ийг байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулсан. Тус кабинетаар иргэдэд ээлтэй үйлчилгээ үзүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөмж хүргүүлсэн.

Архи тамхины шалтгааныг судлах эмнэл зүйн кабинет”-ийг байгуулах талаар аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, тус кабинетэд зориулан 3,4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, техникийн хэрэгслээр хангаж, кабинетийн тохижуулалт хийгдэж, эмчлүүлэгчид ээлтэй орчинг бүрдүүлсэн.

“Архигүй Булган” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн Сэтгэц наркологийн тасагт болон Хутаг-Өндөр, Сэлэнгэ сумдад архидалтын эсрэг эмийн болон сэтгэл зүйн эмчилгээг 80 хүнд үзүүлсэн.

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22.5 хувь /**

**2.32.11 Сүрьеэ, халдварт шар, БЗДХӨ-ийг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх /2013-2016/**

“Халдварт өвчинтэй тэмцэх аймгийн хөтөлбөр”, “Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх стратеги” төлөвлөгөөг боловсруулж Засаг даргын зөвлөлийн хурал, ИТХ-аар хэлэлцүүлж *ᠴᠠᠭᠠᠨ ᠠᠶᠢᠨ ᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠢᠭᠡᠵᠡᠭᠦᠯᠡᠬᠡ*.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар удирдлага зохион байгуулалтын нэгдсэн арга хэмжээ авч, бүх сумдын ЭМБ-*ᠡᠮᠦᠪᠡᠨ ᠡᠮᠦᠨᠡᠯᠭᠡᠢᠨ ᠰᠠᠯᠪᠠᠷ*.

Хүн мал эмнэлгийн салбарт “Нэг дэлхий-нэг эрүүл мэнд” зарчмыг хэрэгжүүлэх “Хүн, мал эмнэлгийн салбар дундын зөвлөл”-ийг байгуулсан байна.

Вирусны гепатит өвчинтэй тэмцэх сэргийлэх чиглэлээр Дашинчилэн, Баяннуур, Гурванбулаг, Баян-Агт, Бүрэгхангай суманд мэргэжлийн баг ажиллаж, халдварт өвчний голомтонд хавьтал болсон 35 иргэн, дотуур байрны 98 хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, үйлчилгээний 51 байгууллагад урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл хийж, голомтын зураглал гаргалаа.

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22.5 хувь /**

**Зорилт 2.33.** Донорын хөдөлгөөн өрнүүлж, цусны аюулгүй байдал, зохистой хэрэглээг бий болгоно.

Хүрэх үр дүн: Цусны аюулгүй байдал, зохистой хэрэглээ төлөвшиж, хүн амын 1,0 хувь нь донор болсон байна.

**2.33.1** Донорын цус цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах аюулгүй байдлыг хангах аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх. **/2013-2016/**

“Донор цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах аюулгүй байдлыг хангах аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 92 хувьтай байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Цусны салбар банк”-ны Донор, цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, зохистой хэрэглээний өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай мэдээллийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж тодорхой асуудлуудыг шийдвэрлүүлэн ИТХ-ын 2013 оны 121 дүгээр тогтоол батлуулж, тогтоолын хэрэгжилтийн хангах талаар бэлтгэл ажлын ханган ажиллаж байна.

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22.5 хувь /**

**2.33.2** Донорын цус, цусан бүтээгдэхүүнийг бэлтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, донорын хөдөлгөөн өрнүүлэх, донор сум, байгууллага шалгаруулах.**/2013-2016/**

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Цусны салбар банкны цус, цусан бүтээгдэхүүнийг хадгалах, чанар аюулгүй байдал, нөөцийг бүрдүүлэх, доноруудад ээлтэй орчин бий болгоход 137 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангахаар төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан.

“Цусны донорын дэлхийн өдөр”-ийг 2013 онд “Амьдрал бэлэлзэе” хүмүүнлэгийн сайн үйлсийн аяны хүрээнд донорын хөдөлгөөн өрнүүлж, 28 байгууллагад үзлэг шинжилгээ зохион байгуулж, 120 хүнийг хамруулснаас 15 хүн шинээр донор боллоо. Сум орон нутагт донор бэлтгэх ажлыг эрчимжүүлэх талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж, донорын эгнээг өргөтгөлөө.

Цусны донорын дэлхийн өдөр"-ийг тохиолдуулан 100 гаруй иргэдэд цусны донорын ач холбогдол, авлагагүй донорын талаар мэдээлэл хийж, цусны "Хүндэт донор"-уудыг шагнаж, урамшуулах алдаршуулах ажлыг зохион байгууллаа.

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22.5 хувь /**

**Зорилт 2.34.** Эмийн чанар аюулгүй байдлыг хангаж, иргэдэд чанарын өндөр шаардлага хангасан эмээр үйлчилнэ.

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд аюулгүй, чанарын баталгаатай, эм биобэлдмэл, уламжлалт эмээр хангагдаж, эмийн зохистой хэрэглээний талаар олон нийтийн мэдлэг дээшилнэ.

**2.34.1** Хүн амыг чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах, хөнгөлөлттэй эмийн зардлыг жил бүр нэмэгдүүлж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, мэдээллийн сан бүрдүүлэх. **/2013-2016/**

Аймгийн хэмжээнд зайлшгүй шаардлагатай эмийн хангамж 88 хувьтай байна  
Эрүүл мэндийн даатгалын сангаас жил бүр хөнгөлттэй эмийн зардлыг нэмэгдүүлэн ажиллаж байгаа ба 2012 онд 108,0 сая 2013 онд 161,0 сая төгрөгийг төсөвлөсөнөөс эхний 10 сарын байдлаар санхүүжилтийн гүйцэтгэл 85%-тай байна.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар "Эрүүл мэндийн даатгалтай иргэдэд хөнгөлттэй эмээр үйлчилж байгаа байдал, цаашид авах арга хэмжээний тухай" мэдээллийг хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын 2013 оны А/421 тоот захирамжаар батлуулсан.

Салбарын хэмжээнд эмийн зохистой хэрэглээг хянах зорилгоор эмийн гаж нөлөөг бүртгэж, мэдээлэх ажил тогтмолжсон ба эмийн гаж нөлөөг бүртгэн ЭМЯ-д улирал тутам хүргүүлж ажиллалаа.

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22.5 хувь /**

**2.34.2** Эрүүл мэндийн газрын дэргэд эм эмнэлгийн хэрэгслийн зориулалтын агуулах барих. **/2013-2016/**

**/Хугацаа болоогүй 2014 оноос/**

**2.34.3** "Нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх стратеги"-ийг батлуулан хэрэгжүүлэх. **/2013-2014/**

"Нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх стратеги"-ийг Эрүүл мэндийн сайдын 2012 оны 448 дүгээр тушаалаар баталсан бөгөөд, тушаалын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**Зорилт 2.35.** Эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар, мэдлэг, боловсролыг дээшлүүлнэ.

Хүрэх үр дүн: Эмч, мэргэжилтнүүдийн 30-аас доошгүй хувь мэргэжлийн зэрэгтэй болно.

**2.35.1** Эмнэлгийн мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах сургалтанд хамруулах хэрэгцээг тодорхойлон 5 жилийн сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэн, үр дүнг тооцон ажиллах. /2013-2016/

*Эмнэлгийн мэргэжилтнүүдийн хөгжлийн төлөвлөгөөг 5 жилээр боловсруулсан ба төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2013 онд төрийн санхүүжилтээр 18 төрлийн мэргэжлээр 49 эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх болон, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулсан.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**2.35.2** Мэргэжлийн нийгэмлэгүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, мэргэжлийн зэрэгтэй эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх/2013-2016 он/

*2013 онд эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн зэрэг горилох шалгалтанд оролцохоор саналаа ирүүлсэн 34 эмнэлгийн мэргэжилтний материалыг журмын дагуу бүрдүүлэн мэргэжлийн нийгэмлэг холбоодод хүргүүлэн ажилласан. Мэргэжлийн зэрэг горилох шалгалтанд оролцсон нийт мэргэжилтнүүдээс 15 мэргэжилтэн шалгалтанд тэнцэж мэргэжлийн тэргүүлэх болон ахлах зэрэгтэй болох эрх аваад байна.*

*Ингэснээр нийт мэргэжилтнүүдийн дунд мэргэжлийн зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтний тоо 85, эзлэх хувь 16.6% болж өмнөх оноос 3,6%, 2010 онтой харьцуулахад 10%-иар нэмэгдсэн байна.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**2.35.3** Эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын байрны солилцох сургалтанд хамруулж, үр дүнг тооцох /2013-2016/

*Эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын байрны солилцох сургалтанд хамруулах чиглэлээр Халдварт өвчин судлалын үндэсний төв, Орхон аймгийн Бүсийн оношлогоо, эмчилгээний төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.*

*2013 оны эхний 9 сарын байдлаар нийт 32 эмнэлгийн мэргэжилтэн халдварт, хүүхэд, дотор, хог хаягдлын менежментын чиглэлээр Халдварт өвчин судлалын үндэсний төв, Орхон аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төв, аймгийн Нэгдсэн эмнэлэгт ажлын байрны солилцох сургалтанд хамрагдсан.*

*Халдварт өвчин судлалын үндэсний төвд Бугат сумын Эрүүл мэндийн төвөөс 1 мэргэжилтэн, Орхон аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвд Бугат сум, Хялганат тосгоны Эрүүл мэндийн төвийн 15 мэргэжилтэн, аймгийн Нэгдсэн эмнэлэгт Орхон, Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төв, Хишиг-Өндөр сум дундын эмнэлгийн 17 эмнэлгийн мэргэжилтэн тус тус хамрагдсан байна.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**Зорилт 2.36.** Эрүүл мэндийн салбарт шаардлагатай шинэ барилгыг барьж, их засвар хийх ажлыг үе шаттайгаар хийнэ.

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн байгууллагуудын ажиллах орчин стандартын түвшинд хүрсэн байна

**2.36.1** Эрүүл мэндийн газрын конторын барилгыг шинээр барих /2013-2016/

*Аймгийн Эрүүл мэндийн газрын конторын шинэ барилга 2013 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй.*

**/Хугацаа болоогүй 2015 оноос/**

**2.36.2** Нэгдсэн эмнэлгийн 50 ортой төрөх эмнэлгийг ашиглалтанд оруулан халдварт, сүрьеэгийн 30 ортой эмнэлгийг барьж ашиглалтанд оруулах/**2013-2016/**

*Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 50 ортой төрөх эмэгтэйчүүдийн эмнэлгийн барилгын ажлын гүйцэтгэл 2013 оны 10 сарын байдлаар барилгын ажил нийт 70 орчим хувьтай байна. Уг барилгын халаалтын шугамд холбогдох техникийн нөхцөл гарвал 50 ортой төрөх эмэгтэйчүүдийн барилгыг энэ онд хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна.*

*Халдварт, сүрьеэгийн 30 ортой эмнэлгийн барилгын хөрөнгийн эх үүсвэр 2013 оны төсөвт тусгагдаагүй болно.*

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**2.36.3** Цоожэд өрхийн ЭМТ-д өргөтгөл, Орхон, Могодод тус бүр 10, Дашинчилэнд 20 ортой ЭМТ-ийн барилга, Хантай, Хужирт багт бага эмчийн салбар, Баяннуур, Хангал суманд ЭЭС-гийн барилга шинээр барих. **/2013-2016/**

*“Цоожэд” өрхийн Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын 85 сая төгрөгний өртөгтэй зураг төсвийн ажил хийгдсэн ба барилгын ажлыг 2014 онд эхлүүлэхээр шийдвэрлсэн.*

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь**

**2.36.4** Нэгдсэн эмнэлэг, Бүрэгхангай, Сэлэнгэ, Гурванбулаг, Рашаант, Баяннуур, Баян-Агт, Хишиг-Өндөр, Тэшиг сумын ЭМТ-ийн их засварыг хийх **/2013-2016/**

*Гурванбулаг, Бүрэгхангай, Хангал сумын Эрүүл мэндийн төвүүдийн барилгын их засварын ажил бүрэн дуусч, улсын комисст хүлээлгэн өгсөн. Сэлэнгэ сумын их засварын ажлыг гүйцэтгэх шатандаа явж байна.*

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22.5 хувь /**

**2.36.5** Түргэн тусламжийн автомашиныг үе шаттай, Нэгдсэн эмнэлгийн Яаралтай тусламжийн тасгийг С ангилалаар тоноглогдсон автомашинаар хангах. **/2013-2016/**

*Улсын онцгой комиссын 42,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баяннуур, Дашинчилэн сумын, ЭМЯ-ны 48.3 сая хөрөнгө оруулалтаар Тэшиг, Рашаант, Хангал сумын Эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийгдээд байна.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**Зорилт 2.37.** Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлэн, эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлэн, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоог 45 болгон нэмэгдүүлнэ

**2.37.1** “Цахим-эрүүл мэнд”, “Эрүүл чийрэг Монгол хүн”, “Эрүүл хүүхэд-Монголын ирээдүй”, “Иргэдийн Эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх”, “Хүн амын амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах”, “Тэгш дүүрэн”, “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2013-2016 онд хөгжүүлэх” аймгийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх. **/2013-2016/**



**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**2.37.5** Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг суурин ба хөдөлгөөнт хэлбэрээр зохион байгуулах **/2013-2016/**

Эрүүл мэндийн сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлэн, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан иргэдэд эрүүл мэндийн мэдлэг, дадал, хандлага олгох 37 удаагийн сургалтанд 18 байгууллагын 3914 албан хаагч, иргэдийг хамруулсан байна.

Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох хөдөлгөөнт сургалтыг 16 суманд зохион байгуулж, 3200 иргэдийг хамруулсан.

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22.5 хувь /**

**2.37.6** Эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн гаралтай хог хаягдлыг халдваргүйжүүлэх автоклаваар хангаж, байгаль орчинд аюулгүйгээр зайлуулан устгах **/2013-2016/**

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Эмнэлгийн гаралтай хог хаягдлыг цуглуулах, хадгалах, халдваргүйтгэх, тээвэрлэх түр цэг”-ийн барилгын тендерийг зарлан, Цонхот ХХК гүйцэтгэгчээр шалгарч барилгын ажлын гүйцэтгэсэн. Барилгын ажлыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдлагууд хүлээн авсан.

Ø ààðààãààð ò ï ï ï ã ò ° ò ° ò ï æ í è è è ç ç è ý õ à æ è è ò á í à à ð è è í ø à ò à í à à à ý à æ à à è í à.

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 165 дугаар тушаалын дагуу 2013 онд Ðàø à à ò ò , Ñà è õ à í ñ ò ï ù í Ýì Ò ç ç à í ù õ ï ã ò à ý à à è ù í ò ç ð ò à à à à è à ò à à è ð ù ã ø è í ý ð à à ð ù æ à ø è è à è ò à í à í ð ò ò è à í í à í í ã í ð í è è ò 9 ñ ò ï ù í Ýì Ò ò ç ð ò à à à à è à ò à à è ð ò à è à í è ñ í í

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

**Иргэдийн нийтийн биеийн тамир, спортоор тогтмол хичээллэх орчин бүрдүүлэн, нийтийн биеийн тамир, их спортыг хөгжүүлнэ.**

**Зорилт 2.38.** Цана, тэшүүр, гар бөмбөг, буудлага, жуд-до, үндэсний сурын спортыг түлхүү хөгжүүлж өсвөр үеийн шигшээ баг хичээллүүлэн, шинэ спортыг хөгжүүлнэ.

Хүрэх үр дүн: Тив дэлхий, олон улсад амжилт гаргах тамирчид төрөн гаргах, алдартай тамирчдын хойч үеийг бэлтгэх аймагт хөгжсөн онцлог спортын төрлүүдийг олон нийтийн хүртээл болгох

**2.38.1.** Өсвөрийн шигшээ баг хичээллүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, материаллаг баазыг нэмэгдүүлэх **/2013-2016/**

Ø è à ø ý ú à à ò è - ý ú è ý õ ý á шаардлагатай байгаа техник хэрэгсэлийн судалгааг авч ñудалгааны дүнã үндэслэн техник хэрэгслээр үе шаттайгаар хангах арга хэмжээ авахаар холбогдох байгууллагуудад санал тавин хамтран ажиллаж байна.

Өà è è è í ñ í ð ò ù ã õ ã æ ç è ý õ ç í ð è è ã í ð Япон улсаас өвлийн спортын хэрэглэл ì à ò à ð è à è ò ó è ù í ò à ì à 142ø , ò ð à è à à à ì ù ò à ì à 51ø , ñ í í ó á í ð à 13ø , ò ý ø ç ç ð 40 õ í ñ , ò à ì ù í à ò ò à è 65 õ í ñ , ñ í í ó á í ð à ì ù í à ò ò à è 2 õ í ñ ò ò ñ ò ò ñ ò ç è ý ú ý á à à ç , замын зардалд 10 гаруй сая төгрөг зарцуулаад байна.



Үндэсний бөхийн спортыг хөгжүүлэхэд анхаарч “Хөдөөгийн хүчтэн” УАШТэмцээнд багаараа мөнгөн медаль хүртэж улсын болон аймгийн баяр наадамд барилдсан бөхчүүдийн бэлтгэл сургалтын зардал туслалцаа үзүүллээ.

“Морьтон монгол” гиннессийн дээд амжилтанд бүртгүүлэх 11125 и î ðüò î í î í î ãî ë-óóäüí î ð ããñààë, 4249 î î ðüäüí î ðàëëääàî ä Áóëääî àèî äààñ 697 î î ðü ããñààë 564 î î ðü ðàëëäñàî á°ä°ä Äàýí î ðóð ñòî òàî äëéí î ëí î î ðü ããñààñàî áàéí à.

**/Тухайн жил 90 хувь/  
/Өссөн дүнгээр 22,5 хувь/**

**Зорилт 2.39.** “Шатар” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

Хүрэх үр дүн: Шатрын спортын амжилт ахисан байна.

**2.39.1.** “Шатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, Шатрын клубуудын үйл ажиллагааг дэмжих **/2013-2016/**

Өсвөрийн шигшээ баг, хүүхэд багачуудын шатрын спортоор хичээллэхэд онцгой анхааран ажиллаж байгаа шатрын “Сөрт” клубыг хэрэглэл материалаар хангах ажлыг зохион байгууллаа. Клубын үйл ажиллагааг дэмжиж стандарт шатар 10, стандарт цаг 10, нөүтбүүк, иж бүрэн компьютер, принтер олголоо.

Хөтөлбөрийн хүрээнд сум болгонд стандарт шатар, стандарт шатрын цаг тус бүр 2-ыг олгосноос гадна сумдууд өөрсдөө шатрын клуб сонирхогчдын баг байгуулан ажиллаж байгаагаас гадна төрийн болон төрийн бус байгууллагууд өөрсдийн ажилчдын амралт болон чөлөөт цагийг өнгөрөөх өрөө тасалгаандаа шатартай, шатар тоглох нөхцөл бололцоог бүрдүүлэн ажиллаж байна. Сумдад шатрын клуб байгуулагдаж 1560 õ¿õüä ø àò ðààð òë-ýýëëýæ áàéãàà нь 2013 онд дэвшүүлсэн нийт суралцагчдын 15% хүргэнэ гэсэн зорилтоос 1.4% аар илүү үзүүлэлттэй байна.

**/ Тухайн жил 90 хувь/  
/Өссөн дүнгээр 22.5 бувь/**

**2.39.2** Өсвөр үеийн Шатрын шигшээ багийг хичээллүүлэх, шигшээ багийн болон сургагч багш нарыг сургах, бэлтгэх, мэргэшүүлэх **/2013-2016/**

Сумдын сургагч багш, сургуулийн сургагч багш, цэцэрлэгийн ахлах бүлгийн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулан 70 сургагч багшийг бэлтгэн тэдэнд орчин үеийн шатрын программ бүхий сд, ном товхимол, гарны авлага, сэтгүүл зэргийг олголоо

Шатраар гүнзгийрүүлэн хичээлэгч хүүхдүүд, сургагч багш нарын зуны сургалтыг “Жаргалант” хүүхдийн зусланд зохион байгуулан 22 сурагч, 5 багш хамрагдлаа.

Сөрт клубт өсвөрийн шигшээ багт орох тамирчдыг бэлтгэж байгаа бөгөөд шигшээ багийг байгуулах, үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардлыг 2014 оны төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**2.39.3.** Шатрын шигшээ багийн тамирчдыг улс, бүс, орон нутгийн тэмцээнүүдэд тогтмол оролцуулах **/2013-2015/**

Өсвөр үе, “Цодгор хүү”, насанд хүрэгчид хагас шигшээ, “Рapid” шатрын, Түргэн тоглолтын, “Монгол туургатан”, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймгуудад болсон

тэмцээнүүдэд тамирчдаа оролцуулж анх удаа сонирхогчдын шатрын төрлөөр Б.Янжинлхам Дэлхийн аваргын алтан медалийг авчирлаа.

“Өсвөр үе”, “Насанд хүрэгчид”, “Үнэмлэхүй аварга” гэсэн төрлүүдээр аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Үндсэн хуулийн өдрийн, “Шатар” хөтөлбөрийн нээлтэнд зориулсан 100 шатарчдын зэрэг тоглолт, Үндэсний их баяр наадамд зориулсан тэмцээн, нэрт шатарчин Түгж агсаны нэрэмжит тэмцээн, Булган сумын багийн аварга шалгаруулах тэмцээн, Монос Группын нэрэмжит тэмцээн, Монгол улсын Их хурлын ивээл дор зохион байгуулагдах насанд хүрэгч сонирхогчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг тус бүр зохион байгууллаа.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**2.39.4. 2013-2015/**

Шатар хөтөлбөрийн үр дүнгээр 2016 онд 1000 шатарчдын баяр зохион байгуулах бөгөөд 2013 онд давхардсан тоогоор 1400 гаруй тамирчид тэмцээн уралдаанд оролцоод байна.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**Зорилт 2.40.** Сум бүр /ЕБС/-т ногоон байгууламж бүхий чийрэгжүүлэлт, биеийн тамир, спортын болон хөл бөмбөг / мөсөн гулгуур/ -ийн талбай, гүйлт, дугуйн зам байгуулна.

Хүрэх үр дүн: Сумдын хүүхэд залуучууд, ард иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, дасгал хөдөлгөөн хийх зориулалтын талбайтай болж иргэд өөрсдийн санаачлагаар идэвхитэй дасгал хөдөлгөөнийг хийж хэвшинэ.

**2.40.1** Ногоон байгууламж бүхий алхалт, гүйлт, дугуйн зам байгуулах **/2013-2016/**

Хутаг-Өндөр 350-ийн 2 цэцэрлэгт хүрээлэнд алхалт, гүйлт, дугуйн замын хэмжилт хийн зураг төсөв гаргах, Сум бүр ногоон байгууламж бүхий алхалт гүйлтийн талбай байгуулах ажлыг амжилттай гүйцэтгэж, өөрсдийн санаачлагаар идэвхитэй дасгал хөдөлгөөнийг хийж хэвшинэ.

**Тухайн жил 50,0 хувь/  
/Өссөн дүнгээр 12,5 хувь/**

**2.40.2** Хөл бөмбөг, мөсөн гулгуурын талбай байгуулах **/2014-2015/**

**Өөрсдийн санаачлагаар идэвхитэй дасгал хөдөлгөөнийг хийж хэвшинэ.**

**Зорилт 2.41.** Усан бассейн байгуулж, бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлж байгууллага, аж ахуйн нэгжүүд, “Чийрэгжүүлэх фитнес төв”-тэй болох, спортын холбоод, хамтлагуудын үйл ажиллагааг дэмжих, амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагчдыг урамшуулна.

Хүрэх үр дүн: 16-аас дээш насны хүн амын 60.0 хувь нь нийтийн биеийн тамираар хичээллэдэг болно.

**2.41.1** Кино театр, усан бассейн бүхий хүүхэд, залуучуудын хөгжлийн цогцолбор байгуулах **/2013-2016/**

Кино театр усан бассейн бүхий хүүхэд залуучуудын хөгжлийн цогцолборыг барих газрын асуудлыг аваргуудын хөшөөний зүүн талд барихаар шийдвэрлэж Ойаи бассейны барилгын ажлын зураг төслийн холболтын ажлын зургийг “Нийслэлийн зураг төслийн хүрээлэн”-ò үе айуу айааоооаи айеюуò айеаааеи à.

**/Тухайн жил 50 хувь/  
/Өссөн дүнгээр 12.5 хувь/**

#### **2.41.2 Булган суманд биеийн тамир чийрэгжүүлэлтийн төв байгуулах**

Булган сумын хэмжээнд ССАЖГ-ын дэргэдэх “Power full” фитнес клуб бө-:ууеюи 150 бдауа, 30 бжжбуйа бәи бәааасан байна.

Биеийн тамир чийрэгжүүлэлтийн төв барих асуудлыг сумын удирдлагатай ярилцаж 2014 онд зураг төсвийг хийхээр болсон.

**/Тухайн жил 30 хувь/  
/Өссөн дүнгээр 10 хувь/**

**2.41.3 Байгууллага, аж ахуйн нэгжүүд “Чийрэгжүүлэх фитнес төв”-тэй болох хөдөлгөөн өрнүүлэх, Тэргүүний үлгэр жишээ фитнес төв шалгаруулах /2013-2016/**

Аймгийн хэмжээнд байгууллага, аж ахуйн нэгжүүдэд ажилчдынхаа чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндэд нь анхааран амралтын өрөө, теннис, чийрэгжүүлэлтийн танхим 18, нийт 50 гаруй чийрэгжүүлэлтийн танхим үйл ажиллагаагаа явуулж байна.

16 суманд “Тэргүүний чийрэгжилтийн танхим” шалгаруулах болзлыг оаебдәәи аеәә бжжбуйеюи 12 сард дүгнэхээр төлөвлөгдөж байна.

**/Тухайн жил 70 хувь/  
/Өссөн дүнгээр 17,5 хувь/**

#### **2.41.4 Спортын холбоодын ажлыг дүгнэх журам гарган хэрэгжүүлэх /2013-2016/**

Спортын холбоодыг үнэлж дүгнэх, санхүүжүүлэх, урамшуулах журмын төслийг гарган холбогдох газрууд, спортын холбоод, биеийн тамирын багш дасгалжуулагчдаас санал авах хэлэлцүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд хэлэлцүүлэн батлуулахад бэлтгээд байна.

**/ Тухайн жил 50 хувь/  
/Өссөн дүнгээр 12,5 хувь/**

**2.41.5 Нийтийн биеийн тамирын хөтөлбөрийг хэрэгжүүлж, сум, байгууллагын биеийн тамирын арга зүйчдийг мэргэшүүлэх, сургах, бэлтгэх /2013-2015/**

И еөд ееи аеәәеи о аи бдуй о о еә о бөеә буйуааежжәеи дйи о и и и и аои бдәә ççе-еә, биеийн тамирын багш, эрүүл мэндийн арга зүйчдийг хамарсан “Биеийн тамир, чийрэгжилт” сэдэвтэй сургалтыг амжилтай зохион байгуулан 16 сум аймгийн о о аеи 60 бж бәи бәоооәә.

Аймгийн Засаг даргын шийдвэрээр Монгол улсын ерөнхийлөгчийн 53 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн сорил судалгааг авч ССАЖЯамны санхүүжилтээр төсөл хэрэгжүүлж байна

**/Тухайн жил 90,0 хувь/  
/Өссөн дүнгээр 22,5 хувь/**



*“Олуулаа ном уншъя” аяныг зохион байгуулан хүүхдийн зохиолч Нацагдорж, Сундуй, Булган аймгийн хүүхдийн зохиолч Ц.Чинбат, ахмад багш Н.Дагвадорж, Бад нартай уулзалт зохион байгуулж аймгийн “Оюунлаг сурагч”-дийг шалгаруулан “Манай Ирээдүй” сониноор сурталчиллаа.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**3.42.2.** СӨБ, бага, суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, “Хөдөөгийн нүүдэлчин болон шилжин суурьшсан иргэдийн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол” олгох төслийг хэрэгжүүлэх **/2013-2016/**

Аймгийн хэмжээнд 132 нөхөрлөлтэй болсон ба энэ онд 32 нөхөрлөл ойн менежментийн төлөвлөгөөг шинээр батлууллаа. Орхон, Бугат, Хангал, Сэлэнгэ сумын 12 нөхөрлөлд хүлэмж, усалгааны систем, үр, нарнаас хамгаалах тор болон бусад багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулав. Бугат сумын “Дундат өргөө” нөхөрлөлийн газар дээр хүлэмж барьж, нарс, шинэсний үр тарих үзүүлэх сургалт хийж нөхөрлөлүүдэд заавар зөвлөгөө өглөө.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**4.56.3.** Мод тарих, цэцэрлэгжүүлэх, ойн зурвас байгуулах ажилд олон нийтийг хамруулж, урамшуулах механизмыг бүрдүүлэн, жилд 1000-аас доошгүй га-д ойжуулалт нөхөн сэргээлтийн ажил хийх. /2013-2016/

Аймгийн хэмжээнд 114657 ширхэг мод бутыг 198 байгууллага, аж ахуй нэгжийн 4182 хүн оролцон 202974.3 мянган төгрөгний зардал гарган тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлээд байна. Аймгийн хэмжээгээр нийт 869 га-д ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажил хийлээ. Үүнээс Ногоон хэрэм хөтөлбөрийг хэрэгжүүлж Рашаант, Дашинчилэн, Гурванбулаг суманд 45 га-д хамгаалалтын ойн зурвас байгуулсан.

**/Тухайн жил 90 хувь/  
/Өссөн дүнгээр 22,5 хувь/**

**4.56.4.** Ойгоос нойтон мод бэлтгэж хэрэглэхийг таслан зогсоох, ойн цэвэрлэгээнээс гарсан модыг түлшинд хэрэглэх, мод боловсруулах дэвшилтэт технологи бий болгох. /2013-2016/

Түлшинд нойтон мод хэрэглэхийг зогсоож, зөвхөн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагаар ойн цэвэрлэгээ хийлгэж, гарсан модоор түлшний хэрэгцээг хангаж арга

хэмжээг авлаа. Булган сумын хэмжээнд 4 компани, 14 нөхөрлөлийн бэлтгэж, үйлдвэрлэсэн 3460 м3 мод, 30 тн шахмал түлшийг 4 захаар дамжуулан иргэдэд нийлүүллээ. Нүүрсний уурхайтай 1500 тн нүүрсний гэрээ байгуулж, түлшний захаар дамжуулан иргэдэд олгохоор ажиллаж байна.

**/Тухайн жил 90 хувь/  
/Өссөн дүнгээр 22,5 хувь/**

**4.56.5.** Жил бүр 250.0 мянган га ойн талбайд хөнөөлт шавьж, өвчний тархалтын судалгаа, 20.0 мянган га талбайд хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх ажил хийнэ. **/2013-2016/**

Орон нутгийн болон улсын төсвийн хөрөнгөөр ойн хортон шавжтай тэмцэх ажлыг явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээр 250.0 мянган га талбайд судалгааны ажлыг хийлгэлээ. Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 8 сумын нутагт 20000 га-д, улсын төсвийн хөрөнгөөр 3 суманд 11250 га-д, нийт 31250 га талбайд хортон устгалын ажил хийж гүйцэтгэлээ. “Ой судалгаа хөгжлийн төв” УТҮГ-аас хортонтой тэмцэх гэрлэн урхийг 500 га талбайд тавьж туршиж үзсэн нь үр дүнтэй ажил боллоо.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**Зорилт: 4.57** “Цөлжилттэй тэмцэх” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, бүе-үүдийг сэлгэж ашиглах, *oi doi i i yda-eaoye oyi oyo, oiaoeaao, oaeoeaainai oaeaaeai i ooi i ydaoye, i ei i i aho odoi eu i id oadeaex* зэргээр байгаль аясаараа нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлнэ.

Хүрэх үр дүн: “Цөлжилттэй тэмцэх хөтөлбөр”, “Ногоон хөгжлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилт хангагдаж, бэлчээрийн менежмент сайжирна.

**4.57.1.** Мэргэжлийн байгууллагуудтай хамтран цөлжилтийн зэрэглэлийг шинэчлэн тогтоох. **/2013-2014/**

Рашаант суманд цөлжилтийн судалгааны төвийг байгуулж, орон нутагт нь дасан зохицсон ургамлыг судлан нутагшуулах судалгааны ажлыг хийж байна. Цөлжилт элсний нүүдлийг тогтоон барих зорилгоор Рашаант, Дашинчилэн, Гурванбулаг суманд 45 га талбайд чацаргана, хайлаас, гүйлс, улиас, бургас зэрэг модыг тарьж ургуулан арчиллаа. 2014 онд цөлжилтийн зэрэглэлийг шинэчлэн тогтоох, нарийвчилсан судалгааг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

**/Тухайн жил 70 хувь/  
/Өссөн дүнгээр 30 хувь/**

**4.57.2** Бэлчээрийн олон наст ургамалын үрийг атаршиж өнжөөсөн, талхлагдсан талбайд тариалж, бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх **/2013-2016/**

**Хугацаа болоогүй 2014 оноос хэрэгжинэ.**

**4.57.3** Хөдөөгийн усан хангамжийг сайжруулж усан сан цөөрөм барих, худаг гаргах замаар жил бүр 24,0 мянган га бэлчээр усжуулах. **/2013-2016/**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Булган-Ус”, “Булган-Ундрага”, “Газрын гүний ус” ХХК-ууд 375.0 сая төгрөний 25 худаг, ХЯБХН-н төслийн хөрөнгөөр Гурванбулаг 2, Дашинчилэн 2, Рашаант 2, нийт худгийг гаргаж улсын комисст хүлээлгэн өгөв.

Мөн малчдын хувийн хөрөнгө оруулалтаар 7 худаг гаргаснаар аймгийн дүнгээр 26 мянган га талбайг усжуулав.

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**4.57.4.** Сум дундын отрын бүс нутгийг тогтоож, хашиж хамгаалах, тэмдэгжүүлэх **/2013-2016/**

Абаадо -900, Аао ёи -ёёуи -19200, Ё дõи -1076, Ёуёуи аý-16400, Оаи ааё-2800, Оёо ёа-Өндөр-21656, Ооо аа-а и а° õ-1390, Дао ааи о -4756 га буюу 68169 га бэлчээрийг нõi äõи äи и ò õи и áçи и оò ааар тогтоов.

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**4.57.5.**Төв суурин газрын болон хөрсний элэгдэл, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх. **/2013-2016/**

“Цэвэр орчин” аяны хүрээнд төв суурин газрын хог хаягдлыг цэвэрлэж, хөрсний бохирдлыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг тогтмол хийж байна. Байгаль хамгаалах сангийн 159.6 сая төгрөгөөр Дашинчилэн суманд уул уурхайн нөхөн сэргээлтийг 8 га-д хийлээ.

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**4.57.6.**О° ёæёёдийн эсрэг ойн цõбââñûã æёё áçõ 20-оос доошгүй аа ааçàðò áàæõóõах. **/2013-2016/**

“Ногоон хэрэм”-ийн туслах зурвасыг 3 сумын нутагт нийт 45 га талбайд байгууллаа.

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**4.57.7.**Төв суурин газрыг цэцэрлэгжүүлж, ногоон байгууламжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлэх. **/2013-2016/**

Аймгийн Засаг даргын Захирамжаар “Цэвэр орчин бодит ажил-2013” сарын аяныг зарлаж, нийт 114657 ширхэг мод бутыг ногоон байгууламжийг нэмэгдүүлээд байна.

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**Зорилт: 4.58** Усны нөөцийн чанарын стандартыг хангах, усыг зохистой ашиглах, хамгаалах оновчтой арга, технологийг судалж нэвтрүүлнэ.

Хүрэх үр дүн: Аймгийн хэмжээнд усны нөөцийг тогтвортой барих нөхцлийг хангаж, иргэд эрүүл ахуйн шаардлага хангахуйц үндны усаар хангагдана.

**4.58.1.** Газрын доорхи усны нөөцийг хэмнэх бодлого гаргаж хэрэгжүүлэх. **/2013-2016/**

Хур бороо, цасны илүүдэл усыг ашиглах, голын урсацад тохируулга хийх замаар гадаргын усыг хуримтлуулж газрын доорх усны хэрэглээг багасгах бодлого барьж байна. Энэ талаар “Ногоон хөгжил-Булган” хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгаж батлууллаа.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**4.58.2.** Цас борооны усыг хуримтлуулах, шаардлагатай жижиг голын урсацад тохируулга хийх замаар гадаргын усны хуримтлал бий болгох. **/2013-2016/**

*Улсын төсвийн 68.4 сая төгрөгөөр Могод сумын Бумбатын голд хөв цөөрөм байгуулан ашиглалтад орууллаа.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**4.58.3.** Уул уурхайн зориулалтаар хаягдал усыг эргүүлэн ашиглахыг дэмжих. **/2013-2016/**

*“Эрдэнэт үйлдвэр” ХХК нь технологийн зориулалтаар тайлант хугацаанд 60.0 сая шоо метр усыг эргүүлэн ашиглаж байгаагийн дээр Бүрээхангай сумын нутагт алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн ус хэрэглээний 60-70 хувийг далан байгуулан тунгаах замаар эргүүлэн ашиглуулдаг болсон.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**4.58.4.** Жилд 50-иас доошгүй булаг шандын эхийг хашиж хамгаалах. **/2013-2016/**  
*Байгаль хамгаалах сангийн 182.2 сая төгрөгөөр нийт 48 булгийн эхийг хашиж хамгаалах арга хэмжээг хэрэгжүүллээ.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**4.58.5.** Хатаж ширгэсэн нуур, цөөрмүүдийг сэргээж, бэлчээр ашиглалтыг сайжруулах. **/2013-2016/**

*Аймгийн уст цэгийн тооллого, судалгааны ажлыг 23.0 сая төгрөгөөр хийж, материалыг нэгтгэж байна. Уг судалгааны дагуу нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ажиллах болно. Баяннуур, Дашинчилэн сумын нуур сэргээх төслийг судалж байна. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2013 онд бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, хөв цөөрөм байгуулах санал ИТХ-аас дэмжигдээгүй тул 2014 онд хэрэгжүүлэхээр санал боловсруулаад байна.*

**/Тухайн жил 50 хувь/  
/Өссөн дүнгээр 12,5 хувь/**

**4.58.6.** Ус зөөлрүүлэх төхөөрөмжийг жил бүр 14-өөс доошгүй худаг, усан сан, уст цэгүүдэд суурилуулах. **/2013-2016/**

*Аймгийн төвийн нэгдсэн усан сан, сумдын худгуудад ус цэнгээжүүлэх, зөөлрүүлэх тоног төхөөрөмж суурилуулах хөрөнгийг шийдвэрлэж гүйцэтгэгчийг шалгаруулсан бөгөөд одоогоор 10 сумын 14 худагт төхөөрөмжийг суурилуулсан.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**4.58.7.** Уст цэгүүдийн эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөх. **/2013-2014/**

*Усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлсний дүнд шинээр зөрчил гараагүй болно.*

**/Тухайн жил 100 хувь/**

**/Өссөн дүнгээр 25 хувь/**

**4.58.8.** Усны эрүүл ахуй, ариутгал, халдваргүйжүүлэлтийг бүрэн хийх. /2013-2016/

Булган сумын 6 усан сан, 1 усны машинд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг хийлээ. Жил бүрийн 5 дугаар сард багтаан ус түгээх цэгүүдэд халдваргүйжүүлэлт хийж байх талаар сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчдэд үүрэг, чиглэл өгч ажиллалаа.

**/Тухайн жил 70 хувь/  
/Өссөн дүнгээр 17,5 хувь/**

**Зорилт: 4.59** Байгалийн ургамал, зэрлэг амьтдын удмын санг хамгаалж, боломжтойг нь нөхөн сэргээх замаар үр өгөөжийг нь дээшлүүлж, хүн ам, аж ахуйн хэрэгцээнд зохистой ашиглах боломжийг бүрдүүлнэ.

*Хүрэх үр дүн: Биологийн төрөл зүйлийн хадгалалт, хамгаалалтын оновчтой механизм бүрдэнэ.*

**4.59.1.** Ургамлын тооллого, судалгаа хийж, хамгаалах нөхөн сэргээх, нутагшуулах, ховордож байгаа ургамлыг орон нутгийн хамгаалалтанд авах. /2013-2016/

*Нэн ховор, ховор, ашиглалтад өртөмтгий ашигт ургамлын тооллого, судалгаа хийх ажлын гүйцэтгэлээ. Мөн ховор ургамал болох Баян-агт сумын “Заан хүж” Тэшиг сумын “Шудаг өвс”-ийг хамгаалах ажилд 2 идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулж байна.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**4.59.2.** Ан амьтдын агнуур зохион байгуулалт хийх, агнуурын амьтдын менежментийн төлөвлөгөө боловсруулж, ховор амьтны байршил нутгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хамгаалах, нутагшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх. /2013-2016/

*Агнуур зохион байгуулалтын ажлын гүйцэтгэгчээр “Амьтан асралт” ХХК шалгарч, нутаг дэвсгэрийн хэмжээнд ангийн тооллого хийж, агнуур зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**4.59.3.** Ган, зудын гамшиг тохиолдсон үед амьтдыг авран хамгаалах, тэдгээрт өвс тэжээл, хужир шүү тавих зэрэг биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлж, тоо толгойг хомсдохоос сэргийлэх. /2013-2016/

*Ган, зудын гамшиг тохиолдсон үед зэрлэг ан амьтдыг тэжээх өвс бэлтгэх, хужир тавих, зохиомол үүр, саравч хийх ажилд зориулж, 8,0 сая төгрөг шийдвэрлэлээ. Ангийн тооллого, агнуур зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан 8 суманд биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлж байна.*

**/Тухайн жил 70 хувь/  
/Өссөн дүнгээр 17,5 хувь/**

**Зорилт: 4.60** Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлнэ.

*Хүрэх үр дүн: Түүх соёлын дурсгалт зүйлс, байгалийн үзэсгэлэнт болон цогцолбор газрууд, ховор амьтан, ургамлын өсөж, үржих таатай нөхцлийг бүрдүүлж, газар нутаг хамгаалагдана.*

**4.60.1.** Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах газар нутгийн судалгааг хийж, тусгай хамгаалттай газар нутгийн хэмжээг жил бүр нэмэгдүүлэх. /2013-2016/

*Тусгай хамгаалалтад авах газар нутгийн талаарх мэдээллийг сумдаас авч нэгтгэн судалгаа хийж байна. Сумын Засаг дарга, байгаль хамгаалагчдын үр дүнгийн гэрээнд байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг орон нутгийн хамгаалалтанд авах, хамгаалалтын бүсийг тогоох ажлыг тусгаж өгсөн.*

**/Тухайн жил 70 хувь/  
/Өссөн дүнгээр 17,5 хувь/**

**4.60.2.**Тусгай хамгаалалттай газар нутгийг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх. /2013-2016/

*Рашаанит сумын Хөгнө тарны тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбрийг хэрэгжүүлэх зорилгоор Сумын ИТХ-ын 36 тоот тогтоолоор “Элсэн тасархайд тэмээ унуулж буй иргэдийн харилцааг зохицуулах” журам, “Элсэн тасархай-Хөгнө хан уул орчим аялал жуулчлалын зам маршрутыг мөрдөж ажиллах тухай”, “Эко гэр кэмп” ажиллуулах журмыг батлуулан аялал жуулчлалын хамгаалалтын бүсэд хориглох 16 тэмдэг, байгаль орчныг хамгаалах уриалга, санамж бүхий сурталчилгааны 26 самбарыг байрлуулаад байна.*

*Элсэн тасархай орчимд Морь тэмээ унуулдаг 40 гаруй иргэн, 10 гаруй малчин өрх жуулчинд үйлчилгээ үзүүлэн орлого олж байна.*

*Байгаль орчин, танин мэдэхүйн явган аялалыг зохион байгуулж ЕБС-ийн сурагчдыг хамруулсан.*

*Сумын иргэдийг хамруулан “Замд гарья” нэртэй аялалын тэмцээнийг зохион байгууллаа.*

*Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газарт аялал жуулчлалын бүтээгдэхүүний нөөцийг тодорхойлох судалгаа хийгдэж аялалын маршрутыг боловсруулж эхлээд байна.*

**/Тухайн жил 90.0 хувь/  
/Өссөн дүнгээр 22.5 хувь/**

**4.60.3.**Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны материаллаг баазыг сайжруулах. /2013-2016/

*Улсын төсвийн хөрөнгөөр Хөгнө тарны тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны шинээр баригдаж буй ажлын байрны засварын ажилд 60 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийлээ. Мөн байгаль хамгаалагч нарыг ажлын хувцас, мэргэжилтнүүдэд ширээ сандал, тоног төхөөрөмжөөр хангалаа. Зэд-Хантай-Бүтээлийн нурууны хамгаалалтын захиргааны ажлын байрыг шинээр барихад зориулж 200 сая төгрөг зарцууллаа. Мөн мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчдыг ширээ, сандал, тоног төхөөрөмж, нормын хувцасаар хангаж ажилчид, албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжрууллаа.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**Зорилт 61.** Оаā оóōí оóüā÷ēēàí ñýðæēēýó ì úáýýēēийн шуурхай байдал, чанар хүртээмжийг нэмэгдүүлж, ¿éē àæēēāāāāñàéæóóéí à.

Хүрэх үр дүн: Цаг агаарын болон орчны мэдээ мэдээллийг чанарын өндөр түвшинд түргэн шуурхай боловсруулж, түгээх нөхцөл бүрдэнэ.

**4.61.1** Агаар, хөрс, усны шинжилгээний лабораторийн барилгын өргөтгөл хийж, лабораторийн үйл ажиллагааг жигдрүүлэх. /2013-2015/

Байгаль орчны шинжилгээний лабораторитой болж агаар, хөрс, усны шинжилгээ хийгдэж байна. Лабораторийн барилгын өргөтгөлийн зураг хийгдсэн бөгөөд 2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийлгэх саналыг БОНХЯ-д хүргүүлээд байна.

*/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /*

**4.61.2** Сумдын цаг уурын харуулуудыг 100 хувь автомат станцтай болгох. /2013-2014/

2014 онд Бүрээхангай, Бугат, Сайхан сумын цаг уурын харуулд автомат станц тавихаар хөрөнгийн эх үүсвэрийг аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхээр судалж байна.

*/Тухайн жил 30 хувь /  
/Өссөн дүнгээр 10 хувь /*

**4.61.3** Орхон сумын “Орхон гол”-ын гүүрний орчимд цаг уурын харуулын ажиглагчийн байртай болгох. /2013-2014/

Хөрөнгийн эх үүсвэрийг аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхээр судалж байна.

*/Тухайн жил 30 хувь /  
/Өссөн дүнгээр 10 хувь /*

**4.61.4** Цаг уур, орчны шинжилгээний албыг газрын доорх усны судалгаа, шинжилгээний цооногтой болгох. 2013-2014

УЦУОША-ны дэргэд газрын доорх усны судалгаа, шинжилгээ хийх, Байгаль орчны шинжилгээний лабораторит ашиглах зорилгоор шинээр гүний худаг гаргалаа.

*/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 90 хувь /*

**Зорилт 4.62.** Газрын нөөцийг шинжлэх ухааны үндэслэлтэй зөв зохистой ашиглах, хот суурины эдэлбэр газруудын харьцааг шаардлагын хэмжээнд зохицуулж, иргэдийн оролцоотой газар зохион байгуулалтын төлөвлөлт хийж, хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн: Хот суурины эдэлбэр газруудын зохистой харьцаа бий болж, газар ашиглах, эзэмших өмчлөх бодлогыг иргэдийн оролцоотойгоор хүүлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

**4.62.1.** Монгол улсын иргэнд нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлэх, аж ахуйн зориулалтаар иргэнд газрыг үнээр нь худалдаж өмчлүүлэх ажлыг зохион байгуулах./2013-2016/

2013 îîú 3-д óëèðüí ááéáëààð 507 èðäýí ä 95.71 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлж өссөн дүнгээрээ 10495 èðäýí ä 2144.2 äà äàçðü ä



**4.62.5.**Инженерийн байгууламж болон зарим барилга, байгууламжийг барьж байгуулах зорилгоор иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшил газрыг нөхөн /2013-2016/

*Булган сумыг “Булган хот” болгохтой холбогдуулан инженерийн байгууламж болон зарим барилга, байгууламжийг барьж байгуулах зорилгоор иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшил газрыг чөлөөлөх, түүнд нөхөн олговор олгох журмыг боловсруулж, аймгийн ИТХурлаар хэлэлцүүлэн батлууллаа. 2014 оноос эхлэн газар чөлөөлөлтийн ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.*

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

#### **Зорилт 4.63** Хүнсний аюулгүй байдал хангах нөхцлийг бүрдүүлэх

**4.63.1** Хүнсний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх. /2013-2016/

*Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013 оны 10 сарын 17-ны өдрийн 23-р тогтоолоор аймгийн “Хүнсний аюулгүй байдал” дэд хөтөлбөрийг хэлэлцүүлэн батлуулж хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Тамхины хяналтын тухай хуулиуд шинэчлэгдэн 2013 оны 03 сараас мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан хүнсний үйлдвэрлэл худалдаа үйлчилгээ эрхлэгч 280 гаруй иргэдэд хууль, холбогдох стандартыг мөрдөх сургалтуудыг 4 удаа зохион байуулж гарын авлагаар хангалаа. “Баясуулагч” захын дэргэд “Дотоод хяналт”-ын мал эмнэлгийн лаборатори байгуулагдаж сүүний уураг, чийг, тослог, махны РН тодорхойлогч багажуудыг шинээр авсанаар хүнсний эрүүл ахуй аюулгүй байдалд хяналт тавих ажиллагааг хялбар түргэн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүллээ. Хүнс, нийтийн хоол, худалдааны газруудад хяналт шалгалтын явцад илэрсэн 11 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 8 албан даалгавар хүргүүллээ.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**4.63.2.** Лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, зарим шаардлагатай техник хэрэгслээр хангана. /2013-2016/

*Хүнсний бүтээгдэхүүнд хүнд металл тодорхойлох багаж “ASS”-ийг шийдвэрлэж, туслахыг Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын Тамгын газарт албан тоотоор хүсэлт хүргүүлэв. Лаброторийн нэн шаардлагатай 87,7 сая төгрөгний багаж төхөөрөмжийн захиалгыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж төсөвт суулгуулахаар санал болгоод байна.*

**/Тухайн жил 50 хувь /  
/Өссөн дүнгээр 12,5 хувь /**

**4.63.3** Сумдад хүнсний аюулгүй байдлын зөвлөлийг ажиллуулна. /2013-2016/

Хүнсний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны 2 дахь үе шат эхэлсэнтэй холбоотойгоор бүх сумдад орон тооны бус зөвлөл байгуулагдан, төлөвлөгөө гарган ажиллаж байна. МХГ-аас мэргэжил арга зүйгээр хангаж ажилладаг.

**/Тухайн жил 70 хувь/  
/Өссөн дүнгээр 17,5 хувь/**

**4.63.4** Хүнсний аюулгүй байдлыг хангахад тавих хяналтын байгууллагын чадавхийг нэмэгдүүлнэ. **/2013-2016**

МХГ нь хими, хор, нян, таримал ургамал, үр хорио цээрийн шинжилгээг хийх лабораторитой болсон. 7 дугаар сард лабораторийг дахин итгэмжлэлд орууллалаа. Хүнсний аюулгүй байдлын хяналтын 1 байцаагч эрүүл ахуй, халдвар хамгааллын 1 байцаагч ажиллаж, хүнсний аюулгүй байдлын хяналтыг тавьж ажиллаж байна. Байцаагчдад шаардлагатай багаж хэрэгсэл дутагдалтай байгаа.

**/Тухайн жил 50 хувь/  
/Өссөн дүнгээр 12,5 хувь/**

**4.63.5** Стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг дэмжиж хүнсний аюулгүй байдлыг хангахуйц тээвэр агуулахын сүлжээ, ложисок байгуулахыг дэмжих. **/2013-2016/**

Аймгийн төвд агуулахын сүлжээ, ложистик тээврийн үйлчилгээний цэг байгуулахаар Булган сумын Булган Барилга ХХК- д 5 га газрыг эзэмшүүллээ. Стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн худалдаалах, аюулгүй хэрэгслээр бараа бүтээгдэхүүнээ татах MNS 5364 2011 стандартыг хэрэгжилтэнд хяналт тавиад байна.

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

Орон нутгийн хамгаалалтанд тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, гадаад харилцааг хөгжүүлнэ.

**Зорилт 4.64** Батлан хамгаалах бодлого зорилт, цэргийн шинэчлэлийн бодлогыг сурталчилна.

Хүрэх үр дүн: *Аàò èàí òàì àààèàò багц хууль орон нутагт хэрэгжих нөхцөл бүрдэнэ*

**4.64.1** Батлан хамгаалах багц хууль болон цэргийн шинэчлэлийн бодлогыг сурталчилна. **/2013-2016/**

Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд болон "Монгол цэргийн өдөр" өнөө цагийн Зэвсэгт хүчин үүсч байгуулагдсаны 92 жилийн ой, Булган аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн "Шинэ Булган 100 хоног"-т нээлттэй хаалганы өдөр, "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" сэдэвт энхийг сахиулах ажиллагааг сурталчлах арга хэмжээ, Цэрэг татлагын товчоо, Оёё







**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**Зорилт: 4.68** Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, харилцан итгэлцлийг гүнзгийрүүлнэ.

Хүрэх үр дүн: Тус байгууллагуудын хамтран ажиллах чадавхи дээшилнэ

**4.68.1** Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ҮАБХ тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд “*Ì àðø òàèòèè, òóñãàé áýèòáýè*”-èéí аварга шалгаруулах тэмцээн зохион явуулна. **/2013-2016/**

*Булган аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ҮАБХ тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд "Марш тактик-тусгай бэлтгэл"-ийн аварга тасаг шалгаруулах тэмцээнийг 3-р сарын 14,15-нд Булган аймгийн Тэшиг суманд байрлах БНМАУ-ын баатар С.Лхагвадоржийн нэрэмжит Хилийн цэргийн 0286-р анги дээр зохион байгуулав.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**4.68.2** ҮАБХ тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд харилцан ажиллагааны төлөвлөгөөтэй хамтран ажиллах. **/2013-2016/**

*Булган аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ҮАБХ тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан ажиллах төлөвлөгөөний хүрээнд хамтран ажиллаж байгаа болно.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**Зорилт: 4.69** Хүүхэд залуучуудад цэрэг, эх оронч хүмүүжил олгоно.

Хүрэх үр дүн: *Àðä èðäýä áí èí í òççòýä çàèòó-òóäýí äóí ä öýðýä, ýò î ðí í ÷ ççýè ò ° è° àø èæ öýðäèéí àèáà òààò òçñýè ñí í èðòí è í ýì ýääýí ý.*

**4.69.1** Цэргийн насны залуучуудад суурь боловсрол нөхөн олгох албан бус сургалтанд хамруулна. **/2013-2016/**

*Бичиг үсэгт тайлагдаагүй цэргийн насны залуучуудыг бичиг үсэгт тайлах бага боловсролтой иргэдийн боловсролын түвшинг дээшлүүлэх талаар БСГ-тай хамтран ажиллаж байна.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**4.69.2** Цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх, албадан эмчилгээ хийлгэх. **/2013-2016/**

*2013 оны 1, 2 дүгээр ээлжийн цэрэг татлагаар эрүүл мэндээр тэнцээгүй эрүүлжүүлэх боломжтой цýðäèéí í àñí ù çàèòó-òóäýí ä àèáàääí ýì -èèäýýí ä î ðóóèäò ажлыг ÝÌ Ñ-ò àé òàì ò ðàí çí òèí í байгуулж 6 иргэнийг эрүүлжүүлэн хугацаат цэргийн албыг ЗХ-ний болон хилийн цэргийн анги байгууллагуудад хаалгаж байна.*

**/Тухайн жил 100 хувь/**



*Цэргийн алба хаасан 4 иргэнийг ХЦ-ийн 0243-р ангид, 6 иргэнийг 0286-р ангид гэрээт хилчиний албанд элсүүлэн анги байгууллагуудад албыг нь үргэлжлүүлэн хаалгаж байна.*

**/Тухайн жил 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/**

**4.70.4** Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, агт хандивлах хөдөлгөөн өрнүүлэх, хилчдийн ахуй нөхцөлийг дэмжих, ажлын байр бий болгох төсөл, хөтөлбөрт хамруулах./2013-2016/

*Хил хамгаалалтанд туслах хүчний зөвлөлийг аймгийн Засаг даргын захирамжаар шинэчлэн байгуулсан. 2 дугаар сард Тэшиг суман дахь Хил хамгаалах ангид Хил хамгаалалтанд туслах хүчний зөвлөлийг хуралдуулж, 2013 оны төлөвлөгөөг батлан ажиллаж байна. Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн агт хандивлах хөдөлгөөн өрнүүлж 60 гаруй агтыг хүлээлгэн өгсөн.*

*Хилчдийн ахуй нөхцлийг дэмжих, гэр бүлийг нь ажлын байраар хангах, мэргэжил олгох төсөл, хөтөлбөрт хамруулан, бүх застав дээр гэр цэцэрлэг ажиллуулж байна.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25хувь /**

**4.70.5** Хил хамгаалах үйлсэд олон нийтийн оролцоог дэмжиж, Сэлэнгэ, Тэшиг суман дахь Хил хамгаалалтанд туслах хүчний зөвлөлийг өргөтгөх /2013-2016/

*Хилийн алба үүсч хөгжсөний 80 жилийн түүхт ойг тохиолдуулан хилийн цэргийн 0243, 0286-р анги, хилийн цэргийн дуу бүжгийн чуулгын бие бүрэлдэхүүн, Булган аймгийн ард иргэд, цэргийн албанд мордож буй залуучуудад хил хамгаалах байгууллагыг сурталчилах арга хэмжээг зохион байгуулав.*

*Мөн Тэшиг суманд хил хамгаалахад туслах хүчний цугларалтыг зохион байгуулж, хил орчмын бүсэд байнга оршин суудаг иргэд болон дүйцүүлэх албаны бие бүрэлдэхүүнтэй гурвалсан гэрээ байгуулан хил хамгаалалтад туслах хүчний аймгийн зөвлөлийг өргөтгөн зохион байгуулав.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**Зорилт 4.71** Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, түүний хор хөнөөлийг арилгах ажлыг сайжруулж, гамшгаас хамгаалах чадавхийг дээшлүүлнэ.

*Хүрэх үр дүн: Гамшиг ослоос хамгаалах чадавхи сайжирна*

**4.71.1.** Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр боловсруулан иргэдийн дунд түлхүү зохион байгуулах. /2013-2016/

*Онцгой байдлын байгууллагын хэмжээнд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх ангиллын сургалтын хөтөлбөрийг батлан хүргүүлсэний дагуу сумдын орон тооны бус штаб, мэргэжлийн анги, иргэд, оюутан сурагчдын ангиллаар 04-р сарын 16-наас 2*

ажлын хэсгийг 16 сумдад ажиллуулж мэргэжлийн анги болон иргэдэд 16 цагийн сургалт зохион байгуулсан.

04-р сарын 06-08-ны өдрүүдэд 16 сумын Засаг дарга, тамгын газрын дарга нийт 32 хүнд ОБЕГ-тай хамтран “Гамшгаас хамгаалах арга хэмжээ” сэдэвт удирдах ажилтны сургалтыг хийж сумдын гамшгаас хамгаалах төлөвлөгөө, түүний дотор газар хөдлөлийн аюулаас хамгаалах чиглэлээр сургалт хийж, төлөвлөгөөг тодотгууллаа.

Мөн Дэлхийн зөн ОУБ-тай “Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдлийг бууруулах” хөтөлбөрийн сургалтыг аймгийн бүх сумдад хийхээр төлөвлөн Булган сумын 1, 6-р багийн 57 хүнд газар хөдлөлтийн чиглэлээр сургалт хийгдлээ.

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22,5 хувь/**

**4.71.2.**Сумдыг объектын болон ой, хээрийн түймэр унтраах багаж зэвсэглэмжтэй болгох. **/2013-2016/**

Энэ онд 13 суманд объектын болон ой, хээрийн гал түймрийг унтраах зориулалттай мотопомп, хоолой хошуу авахаар хөрөнгийг шийдвэрлэн 10-р сарын 7-ны өдөр 11 суманд мотопомп иж бүрдлийн хамт, гал унтраах багаж зэвсэглэмж ДЗОУБ-аас хөрөнгийн дэмжлэг үзүүлж 10 суманд объектын галын гар багаж, хөдөлмөр хамгааллын хувцасыг өгч бэлэн байдлыг хангууллаа. Сумдад ой, хээрийн түймэр унтраах гар багажийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж сумдын Засаг дарга нарт гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч заавал биелүүлэх албан шаардлага өгч 2013 оны Засгийн газрын 106-р тогтоолд заагдсан нормативыг ой, хээрийн түймэр гардаг сум бүрт хангуулах ажлыг зохион байгуулж байна.

Аймгийн Байгаль орчны газрын шугамаар аймгийн ИТХ-д ой, хээрийн түймэр унтраах зориулалтын тусгай тоноглолтой тракторийг шийдүүлэхээр төлөвлөөд байна.

**/ Тухайн жил 85 хувь /  
/Өссөн дүнгээр 20 хувь/**

**4.71.3.**Сумдын гамшгаас хамгаалах удирдлага штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг чадавхижуулах зорилгоор жил бүр 1-2 суманд гамшгаас хамгаалах, команд штабын сургуулийг зохион байгуулж явуулах. **/2013-2016/**

Энэ жил сумдын мэргэжлийн ангиудыг шинэ дүрэмд нийцүүлэн шинэчлэн байгуулж, шинэчилсэн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг сургуулилтаар шалган аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг Булган сумтай хамтран зохион байгуулж 98.8 хувьтай дүгнэгдлээ.

Сургуулийн бэлтгэл ажлын хүрээнд аймгийн 12 алба, 16 сумдын удирдлага штаб, мэргэжлийн ангийн чадавхийг дээшлүүлэх арга хэмжээг авч 2 алын хэсгийг гарган сургалт, дадлагыг 1 удаа зохион байгуулж хийгдлээ.

*/Тухайн жил 98 хувь /  
/Өссөн дүнгээр 24 хувь/*

**4.71.4.** Аврагч нарын ажил үүрэг гүйцэтгэх нөхцлийг сайжруулах зорилгоор аврах салбарын байрыг ашиглалтанд оруулах. **/2013/**

*Эрэн хайх, аврах салбарын барилгыг аж ахуйн аргаар барьж энэ оны 7-р сард ашиглалтанд оруулахаар төлөвлөн ажиллаж, энэ оны 8-р сард ашиглалтанд хүлээлгэн өглөө.*

*/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 100 хувь /*

**4.71.5.** Сэрэмжлүүлэг мэдээ хүргэж байх зорилгоор сумдыг дуут дохиотой болгох. **/2013-2016/**

*Бүх сумдыг дуут дохиотой болгох зорилгоор үнийн санал танилцуулгыг хүргүүлж үйл ажиллагааны төлөвлөгөө гэрээнд тусган энэ чиглэлээр албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтийг дүгнэн ажиллахад Хутаг-Өндөр, Орхон, Бугат сум болон Булган сум 1 ширхэгийг шинээр авч суурьлуулаад байна.*

*/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /*

**Зорилт 4.72** Гадаад харилцааг эдийн засагжуулах, хил залгаа, уламжлалт харилцаатай болон шинээр хөрш орнуудтай харилцаа тогтоож найрсаг харилцааг үргэлжлүүлж, харилцан ашигтай түншлэлийг бататган бэхжүүлнэ.

*Хүрэх үр дүн: Уламжлалт харилцаа өргөжиж, гадаад харилцаа эдийн засагжиж, нутгийн зөвлөлүүдийн хамтын ажиллагаа өргөжсөн байна*

### **Оросын Холбооны Улстай**

**4.72.1.** Тэшиг сумын Бага-Илэнхийн боомтыг байнгын ажиллагаатай болгох талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх. **/2013-2016/**

*Аймгийн Засаг дарга ОХУ-ын Буриад улсын Засгийн газрын нэгдүгээр орлогч дарга С.В.Телинтэй уулзаж, Бага Илэнх-Айнек голын хилийн боомтыг нээх, байнгын ажиллагаатай болгох талаар санал тавив. Уг боомтыг байнгын ажиллагаатай болгох талаар Гадаад харилцааны Яаманд санал хүргүүлээд байна.*

*/Тухайн жилд 50.0 хувь/  
/Өссөн дүнгээр 12.5 хувь/*

**4.72.2.** Тэшиг сумын Бага-Илэнхийн боомтоор мал, мах, түүхий эд гаргах **/2013-2016/**

*Бага Илэнх-Айнек голын хилийн боомт нээгдэх асуудал шийдэгдээгүй тул хүлээгдэж байна. Аймгийн зүгээс шалтгаалах бүх зүйлийг хийж гүйцэтгэсэн болно.*

*/Тухайн жилд 50.0 хувь/  
/Өссөн дүнгээр 12.5 хувь/*

**4.72.3.** Байгаль нуур-Хөвсгөл чиглэлийн маршрут гарган аялал жуулчлалыг хөгжүүлэх /2013-2014/

*ОХУ-ын Буриад улсад аймгийн төлөөлөгчид айлчлахдаа аялал жуулчлал хөгжүүлэх асуудлыг тавиад байна.*

*/Тухайн жилд 25 хувь/  
/Өссөн дүнгээр 8.0 хувь*

**4.72.4.** Хилийн бүс нутагт ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлж, гэрээ байгуулж ажиллах. /2013-2016/

*Хилийн цэргийн отрядтай хилийн бүсэд ой хээрийн түймрээс сэргийлэх чиглэлээр гэрээ байгуулан ажиллаж байгаа ба үүний дүнд 1 удаагийн ойн түймрийг бага талбайд илрүүлэн унтраасан байна. ОХУ-ын Закамень раойнтой байгуулах гэрээний төсөлд тусгаад байна.*

*/Тухайн жилд 80.0 хувь/  
/Өссөн дүнгээр 20.5 хувь/*

#### **Бүгд Найрамдах Хятад Ард Улстай**

**4.72.5.** Мал аж ахуйн чиглэлээр хамтран ажиллах /2013-2016/

*БНХАУ-ын Ху Нань мужийн И Яан хоттой хамтран ажиллах бэлтгэл хөтөлбөрийн баримт бичигт аймгийн Засаг дарга, тус хотын дарга нар гарын үсэг зурлаа. Манай аймаг болон тус хотын хооронд хамтран ажиллах хэлэлцээр байгуулж үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах салбарт хамтран ажиллахаар төлөвлөөд байна. мөн ӨМӨЗО-ны Улаанхад хоттой мал аж ахуйн талаар хамтран ажиллаж харилцаагаа өргөжүүлэхээр санал тавиад байна.*

*/Тухайн жилд 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/*

**4.72.6.** Хүлэмжийн нарийн ногоо тарих арга ажиллагаанд иргэдийг сургах./2013-2016/

*БНХАУ-ын Ху Нань мужийн И Яан хоттой хамтран ажиллах үйл ажиллагааны нэгэн чиглэл нь мэргэжлийн сургалт байхаар төлөвлөөд байгаа юм. Боловсролын салбар болон мэргэжлийн ажилтан бэлтгэх, харилцан солилцох суралцуулах талаар хамтран ажиллахаар хэлэлцээр байгууллаа.*

*/Тухайн жилд 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/*

#### **Бүгд Найрамдах Солонгос Улстай**

##### **Дэгү хотын Дунгү дүүрэгтэй**

**4.72.7.** Газар тариалан, нийгмийн салбарт хамтран ажиллах. /2013-2016/

*БНСУ-ын Дегү хотын Дун-Гү дүүрэгт аймгийн төлөөлөгчид айлчилж, газар тариалан, эрүүл мэндийн салбарт хамтран ажиллаж байсан уламжлалаа улам өргөжүүлэх санал тавьлаа. Эрүүл мэндийн салбарын чиглэлээр эмнэлгийн ажилтнуудын харилцан солилцож, оношлогоо үйлчилгээ хийдэг харилцааг*

үргэлжлүүлж байна. Газар тариалангийн чиглэлээр хамтран ажиллахаар санал тавьж, тус дүүргийн “Насан туршдаа сурцгаая” өдөрлөгт аймгийн төлөөлөгчид оролцлоо. Хөдөө аж ахуй, газар тариаланг эрчимжүүлэх чиглэлийн сургалтад хамрагдлаа.

*/Тухайн жилд 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/*

**4.72.8. Фермерийн аж ахуйг хөгжүүлэхэд хамтран ажиллах. /2013-2016/**

*БНСУ-ын Дегү хотын Дун-Гу дүүрэгтай хамтран ажиллахдаа хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй хөгжүүлэх, бизнесийн харилцааг өргөжүүлэх санал тавьлаа. Орхон, Сэлэнгэ сум, Хялганат тосгонд фермер, хүлэмжийн аж ахуй хөгжүүлэхээр төлөвлөөд байна.*

*/Тухайн жилд 50.0 хувь/  
/Өссөн дүнгээр 12.5 хувь/*

**/БНСУ-ын Кёнсаннам мужтай/**

**4.72.9. Байгаль орчины салбарт хамтран ажиллах /2013-2016/**

*Кенснам аймагтай харилцах харилцааг үргэлжлүүлж Баяннуур суманд ногоон төгөл тарих, тус сумын иргэдэд чацаргана ургуулах арга ажиллагааг зааж нутгийн иргэдийг түр ажлын байраар хангаж ажиллаж байна. Ногоон төглийн ургалт 98 хувьтай байна. БНСУ-ын Кёнсаннам мужийн төлөөлөгчид манай аймагт айлчилж хамтран ажиллах санал тавиад байна.*

*/Тухайн жилд 50.0 хувь/  
/Өссөн дүнгээр 12.5 хувь/*

**4.72.10. Баяннуур суманд бий болгож буй ногоон төгөлийг иргэдийн дэмжлэгтэйгээр өргөтгөх /2013-2016/**

*Баяннуур сумын ногоон төгөлд энэ оны хавар 10000 ширхэг суулгац тарьж өргөжүүлэн, нутгийн иргэдийг түр ажлын байраар хангалаа. Хайлаас 2300 ширхэг, гүйлс 7150 ширхэг, чацаргана, үхрийн нүд 550 ширхэгийг суулгаад байна. Жил бүр уг төглийг өргөтгөх ажил хийгдэж байна.*

*/Тухайн жилд 50.0 хувь/  
/Өссөн дүнгээр 12.5 хувь/*

**Япон Улстай**

**4.72.11. Нүүрсний олборлолт буюу далд уурхайн аюулгүй ажиллагааны чиглэлээр Засгийн газрын дэмжлэгтэйгээр иргэдийг үнэ төлбөргүй дадлагжуулах, сургах ажлыг эхлүүлэх. /2013-2016/**

*Бичил уурхай” төслийн хүрээнд аймгийн хөдөлмөрийн хэлтсийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн сургалтад оролцлоо.*

*/Тухайн жилд 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/*

**4.72.12. Иргэдэд хүлэмжийн аж ахуй бий болгох сургалтыг хийлгэх. /2013-2016/**

*НҮБ-ын хүнс, хөдөө аж ахуйг хөгжүүлэх сангийн “Өвлийн хүлэмж” төслийн шугмаар аймгийн ХАА-н МСҮТ-ийн багш БНХАУ-ын Хөх хотод туршлага судаллаа. Мөн сургуульд НҮБ-ын мэргэжилтэн, Монголын Хүлэмжийн холбооны удирдлага хамтран сургалт зохион байгууллаа.*

***/Тухайн жилд 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/***

**4.72.13. Бизнесийн салбарт харилцан ажиллахыг дэмжинэ./2013-2016/**

*Япон улсын Кюширо хоттой хамтын ажиллаж, аялал жуулчлалыг хөгжүүлж байна.*

***/Тухайн жилд 50.0 хувь/  
/Өссөн дүнгээр 12.5 хувь/***

**4.72.14. Бугат суманд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ. /2013-2016/**

*Тус суманд жуулчдын сонирхлыг татах малчдын ахуй амьдрал, уламжлалт мэдлэг, соёл иргэншилтэй танилцах зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, аялал жуулчлалын брэнд үйлчилгээг бий болгох, байгалийн унаган төрхийг алдагдуулахгүйгээр байгаль орчинд ээлтэй “Эко тур” аялалыг хөгжүүлэх чиглэлээр Япон, Монголын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр хэрэгжиж байна. Уг төслийн 4 дүгээр шатны төлөвлөгөөт ажил явагдаж байна.*

***Тухайн жилд 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/***

**4.72.15. Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах асуудлыг судлах./2013-2016/**

*Дахин холбоо барьж хамтын ажиллагааны асуудлыг хэлэлцэхээр хүлээгдэж байна.*

***/Хугацаа болоогүй/***

**Уламжлалт болон бусад улстай**

**4.72.16. Бизнес, соёл, спорт, аялал жуулчлал, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллах./2013-2016/**

*Уламжлалт харилцаат Украин улсын Киев мужийн Белое Церковь районтой хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр санал тавьлаа. Ялангуяа газар тариалан, хөдөө аж ахуйн чиглэлээр хамтран ажиллах санал санаачлага гаргаад байна.*

***/Тухайн жилд 50.0 хувь/  
/Өссөн дүнгээр 12.5 хувь/***

**4.72.17. Аймагт хэрэгжиж байгаа олон улсын төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоо, үр дүнг сайжруулах./2013-2016/**

*Аймагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах үүднээс ОУБ, ТББ-ын төлөөллийг тогмол хүлээн авч уулздаг бөгөөд байр орон сууц*

болон албаны зориулалт бүхийн барилга барих газрын зөвшөөрөл зэрэг аймгаас шалтгаалах асуудлыг шийдэж өгч байна.

*/Тухайн жилд 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь /*

#### **Бусад аймаг, нийслэлтэй**

**4.72.18.** Орхон аймагтай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах. */2013-2016/*  
Орхон аймагтай хамтран ажиллах гэрээг байгууллаа. Гэрээний хавсралтад 13 чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг тусгалаа.

*/Тухайн жилд 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь/*

**4.72.19.** Улаанбаатар хотын зарим дүүргүүд, бусад аймагтай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах.*/2013-2016/*

Дархан-Уул, Төв, Сэлэнгэ, Орхон, Архангай, Хөвсгөл аймгийн ИТХ, ЗДТГ-тай хамтран ажиллаж жил бүр спортын тэмцээн зохион байгуулж байна. мөн аймгийн Засаг дарга, зарим бодлого хариуцсан мэргэжилтнүүдийн хамт Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгийн төрийн байгууллагын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын ажилтай танилцаж, туршлага судаллаа.

*/Тухайн жилд 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь /*

**4.72.20.** Бусад аймаг хотуудад оршин суух нутгийн иргэдийн зөвлөлүүдтэй хамтран ажиллах.*/2013-2016/*

Аймгийн нутгийн зөвлөлийн уулзалтыг хийхээр төлөвлөж байна. Бүрэгхангай, Дашинчилэн, Сайхан, Рашаант зэрэг сум нийслэл болон бусад хотуудад суух нутгийн иргэдийн уулзалтыг зохион байгуулаад байна.

*/Тухайн жилд 100 хувь/  
/Өссөн дүнгээр 25 хувь /*

**Хууль дээдлэн, гэмт хэргийн гаралтыг бууруулан хүн бүр эрх тэгш, аюулгүй амар тайван орчинд амьдрах нөхцөл, боломжийг бүрдүүлж ажиллана.**

**Зорилт: 4.73** Хууль зүйн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ  
Хүрэх үр дүн: Иргэдэд хууль зүйн тусламж үйлчилгээг авах боломж нэмэгдэн, хүний эрхийн шаардлага стандарт хангагдана.

**4.73.1:** Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх */2013-2016/*

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Иргэдийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 83 дугаар тогтоолоор батлуулсан. 2014 оны 01 сараас эхлэн хэрэгжинэ.

*/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /*

**4.73.2:** Хууль зүйн анхан шатны зөвлөгөө үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж, төлбөрийн чавдаргүй иргэдэд үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх **/2013-2016/**

*Энэ оны эхний 11 сарын байдлаар эрүүгийн анхан шатны 20, давж заалдах шатны 5, иргэний анхан шатны 6, давж заалдах болон хяналтын шатны 1 хэрэгт тус тус төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөлөгчөөр оролцож, иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас эрх зүйн зөвлөгөө авах хүсэлт гаргасны дагуу нийт 123 удаа үнэ төлбөргүй хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгч, өргөдөл нэхэмжлэл, гомдол бичихэд туслалцаа үзүүлэн ажиллаж байна.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**4.73.3:** Сум бүрт “Эрх зүйн хөтөч”-ийн сургагч багшаар бэлтгэнэ. **/2013-2016/**

*аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 83 дугаар тогтоолоор “Иргэдийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг батлуулсан бөгөөд уг хөтөлбөрийг сумдад хэрэгжүүлэх албан тушаалтан нь эрх зүйн хөтөч байхаар тогтоосон бөгөөд хөтөлбөр 2014 оны 01 сараас эхлэн хэрэгжинэ.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**4.73.4.** “Эрх зүйн хөтөч”-өөр дамжуулан сумдад хууль зүйн мэдээлэл, туслалцаа, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах **/2013-2016/**

*аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 83 дугаар тогтоолоор “Иргэдийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг батлуулсан бөгөөд уг хөтөлбөрийг сумдад хэрэгжүүлэх албан тушаалтан нь эрх зүйн хөтөч байхаар тогтоосон бөгөөд хөтөлбөр 2014 оны 01 сараас эхлэн хэрэгжинэ.*

**/Тухайн жил 100 хувь /  
/Өссөн дүнгээр 25 хувь /**

**4.73.5** “Нэг иргэн-нэг бүртгэл” зарчмын хүрээнд Иргэний бүртгэлийн зөрчлийг бүрэн арилгана **/2013-2016/**

*2012 оны 04 сараас хүн амын улсын бүртгэлийн онлайн системийг ашиглаж эхэлсэн бөгөөд иргэний бүртгэлийн зөрчил бүрэн арилсан. Засгийн газраас 0-18 насны хүүхдийн бүртгэлийн зөрчлийг илрүүлэн засах ажил хийгдэж байна. Аймгийн хэмжээнд 1448 хүхэд бүртгэлийн зөрчилтэй гарсаны улсын бүртгэлийн байгууллагаас шалтгаалах 1035 зөрчлийг арилгаад байна.*

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22,5 хувь /**

**4.73.6:** Малчин өрхийг жижиг дунд үйлдвэрлэгчээр бүртгэх ажлыг үе шаттай зохион байгуулах. **/2013-2016/**

*Малчин өрхийг ЖДҮ-ээр бүртгэх үйл ажиллагаа удаашралтай явагдаж байгаа. Шалтгаан нь Татвар төлөгдсөн, НДШ төлөгдсөн байх шаардлага тавигдсан байсантай холбоотой. 2013 оны 06 сард УБЕГ-аас ирүүлсэн чиглэлээр Татвар төлсөн байх шаардлагыг хүчингүй болгосон. Одоогийн байдлаар 79 малчин өрх бүртгэгдсэн.*

**/Тухайн жил 10 хувь /**

**4.73.7:** Хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны талаархи нээлттэй хэлэлцүүлгүүдийг зохион байгуулна. **/2013-2016/**

Хууль зүйн сайдын албан даалгаврын дагуу Булган аймаг дахь хууль хяналтын байгууллагуудын удирдлагууд 14 хоног дутам хамтарсан уулзалт зохион байгуулахаар болсон. Үүний дагуу 2013 онд 9 удаагийн хуралдаан зохион байгуулж хуулийн байгууллагын хамтын ажиллагаагаа сайжруулах зорилго бүхий үйл ажиллагааны төлөвлөгөө батлан гаргаж, 2013 онд зохион байгуулах уулзалтын хуваарь, Гэмт хэргийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг хэрхэн зохион байгуулах болон хуулийн байгууллагын хоорондын уялдаа холбоо зэрэг асуудлаар хэлэлцэж ажиллалаа.

Мөн 2013 оны 03 дугаар сард Хангал суманд Сэлэнгэ, Бугат, Хангал сум, Хялганат тосгоны иргэд төрийн албан хаагчдыг хамруулсан “Шүүх эрх мэдлийн шинэчлэл” нээлттэй хэлүүлцүүлгийг зохион байгуулж хуулийн байгууллагуудын төлөөлөл оролцсон арга хэмжээг зохион байгуулсан. Жил бүр “Үндсэн хуулийн өдөр” болон “Хүний эрхийн өдрөөр хуулийн байгууллагууд хамтран нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж хэвшсэн. Шүүх, Прокурор, Цагдаагийн хэлтэс, Шүүхийн шинжилгээний алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албыг хамруулсан зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулан ажиллаж байна.

Энэ оны 09 сард сайхан сумын Хунт багт Орхон, Дархан-Уул, Хөвсгөл, Сэлэнгэ, Баянхонгор, Төв аймгийн удирдлагууд болон цагдаагийн албан хаагч, Цагдаагийн ерөнхий газар болон Булган аймгийн сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, хил залгаа аймгийн Сумдын удирдлагуудыг нийт 200 хүнийг хамруулсан зөвлөгөөнийг зохион байгуулсан. 10 дугаар сард Орхон аймагт Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар, төвийн бүсийн 8 аймгийн хуулийн байгууллагуудын төлөөлөл оролцсон хэлэлцүүлэгт 25 хүний төлөөлөгч оролцуулсан.

Хууль зүйн хэлтэс, Шүүх, прокурор, ШШГА, Шүүх шинжилгээний алба, Мэргэжлийн хяналтын газар зэрэг хууль хяналтын байгууллагатай хамтран “Гэмт хэрэггүй Булган” зөвлөгөөнийг зохион явуулж, Хэв журмын тасгийн дарга “Хүүхдээс үйлдэж буй гэмт хэрэг, зөрчил, түүний шалтгаан нөхцөл” сэдвээр мэдээлэл хийж, зөвлөгөөнөөс уриалга гаргаж, хэрэгжүүлж ажиллахаар болсон.

**/Тухайн жил 90 хувь /**

**/Өссөн дүнгээр 22,5 хувь /**

**4.73.8:** Хууль хяналтын байгууллагуудын үйлчилгээний чанар, ил тод байдал, хүртээмжийг хэрэглэгчийн үнэлгээгээр үнэлж дүгнүүлнэ. **/2013-2016/**

Хуулийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах зорилготой жил бүр уламжлал болгон батлан гаргадаг үйл ажиллагааны төлөвлөгөөг байгууллагуудаас санал авч нэгтгэн аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргаар батлуулан бүх байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. Мөн Хууль зүйн сайдын албан даалгаврын дагуу 14 хоног дутам хууль сахиулах байгууллагын удирдлагууд уулзалт зохион байгуулж байгууллагуудын дунд тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэж үр дүнг тооцон ажиллаж байна.

Цагдаагийн хэлтсээс 2013 оны эхний хагас жилд ЦЕГ-ын даргын 2008 оны 125 тоот тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Булган, Рашаант, Гурванбулаг, Дашинчилэн, Баяннуур, Хишиг-өндөр, Могод сумдад иргэд олон нийтэд шуурхай хүртээмжтэй ажил үйлчилгээг үзүүлэх, санал хүсэлтийг нь хүлээн авч шийдвэрлэх, хэлтсийн үйл ажиллагааг сурталчилах зорилгоор “Олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа” сэдэвт “Нээлттэй өдөр”-ийг зохион явуулж нийт 1086 иргэнийг хамруулан холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнуудтай хамтран уулзалт зохион явуулж, иргэдийн санаа бодлыг сонсож, Цагдаагийн байгууллагаас зохион явуулж хэрэгжүүлж байгаа ажил, цаашдын бодлого чиглэлийн талаар мөн хууль эрх зүйн чиглэлээр иргэдэд мэдээлэл хийсэн. Дээрхи арга хэмжээний явцад иргэдээс санал асуулгын хуудсаар болон амаар 317 санал, хүсэлтийг хүлээн авч 67-г нь газар дээр нь хариу өгч бусад санал, хүсэлтийг үйл ажиллагаанд хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажилласан байна.

Аймгийн Прокурорын газрын хууль хяналтын байгууллагуудын дунд зохион байгуулсан “Гэмт хэрэггүй булган” зөвлөгөөнд аймгийн Хууль хяналтын байгууллагууд оролцон өөрсдийн байгууллагын онцлогтой холбоотой илтгэлүүдийг хэлэлцүүлсэн. Мөн үйл ажиллагаагаа иргэдэд нээлттэй болгох зорилгоор Олон нийттэй харилцах албанаас эрхлэн гаргадаг “Шинэ булган” мэдээллийн хуудас, “Булганы мэдээ” сонинуудад мэдээлэл байршуулахаас гадна аймгийн [www.bulgan.gov.mn](http://www.bulgan.gov.mn) сайт болон аймгийн Шүүхийн [www.bulgan.court.gov.mn](http://www.bulgan.court.gov.mn), Прокурорын газрын [www.bulganpro.mn](http://www.bulganpro.mn), Цагдаагийн газрын [www.bulgan.police.gov.mn](http://www.bulgan.police.gov.mn) сайтуудыг нээн, өөрсдийн үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.

Мөн хэрэглэгчдээс үнэлгээ авах зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны даргын 2013 оны А/32 тоот тушаал, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтсийн дарга нарын шийдвэрээр үнэлгээний маягт бэлтгэн иргэдээс нээлттэй хаалганы өдөрлөг болон байгууллага дээр тогтмол үнэлгээ аван, гарсан санал, шүүмжлэлийн дагуу тодорхой ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

**/Тухайн жил 90 хувь /  
/Өссөн дүнгээр 22,5 хувь/**

**4.73.9:** Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлж, архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг чанд мөрдөж иргэдэд шуурхай үйлчилнэ. **/2013-2016/**

Хөтөлбөрийн хүрээнд нийт 54 хөмрөгийн 2351 баримтанд иж бүрэн нягтлан шалгалт хийсэн. 1815 баримтын 146786 хуудсыг скайнерт оруулсан. Скайнердсан эдгээр баримтуудыг potoshop программ дээр засварлаж ашиглалтын хувь үйлдэж байна. 1424 иргэнд лавлагаа, тодорхойлолт олгож, 1198 иргэнд хуулбарын лавлагаа олгосон.

**/Тухайн жил 70 хувь /  
/Өссөн дүнгээр 17,5 хувь /**

